



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 46 (427)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай*
- *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2006 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны арванхоёрдугаар сарын 7

№46 (427)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | |
|-------|---|-----|
| 1056. | Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай | 986 |
| 1057. | Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 992 |
| 1058. | Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 992 |
| 1059. | Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 992 |
| 1060. | Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 993 |
| 1061. | Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай | 993 |
| 1062. | Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 993 |
| 1063. | Төв банк /Монгол банкны/-ны тухай хуульд нэмэлт оруулах тухай | 994 |
| 1064. | Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 994 |
| 1065. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 994 |
| 1066. | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 995 |
| 1067. | Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 995 |
| 1068. | Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 996 |
| 1069. | Монгол Улсад амьдарч буй ОХУ-ын цагаач иргэдэд эзэмшиж байгаа орон сууцыг нь үнэ төлбөргүй хувьчлах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай | 999 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|-------|---|-----------|------|
| 1070. | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг батлах тухай | Дугаар 67 | 999 |
| 1071. | Төрөөс мөнгөний бодлогын талаар 2006 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай | Дугаар 68 | 1006 |
| 1072. | Тогтоолын төсөл батлах тухай | Дугаар 69 | 1007 |
| 1073. | Монгол Улсын 2004 оны улсын төсвийн гүйцэтгэлийг батлах тухай | Дугаар 70 | 1007 |
| 1074. | Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай | Дугаар 71 | 1008 |
| 1075. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 72 | 1008 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

| | | | |
|-------|--|--------------|------|
| 1076. | Ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 02/08 | 1008 |
|-------|--|--------------|------|

2005 оны 11 дүгээр
сарын 17-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь санхүүгийн зохицуулах хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

2.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль³, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль⁴, Даатгалын тухай хууль⁵, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль⁶, Хоршооны тухай хууль⁷, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуульд заасан санхүүгийн үйлчилгээнд дараахь үйл ажиллагаа хамаарна:

3.1.1. банк бус санхүүгийн байгууллагын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа;

3.1.2. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;

3.1.3. даатгагчийн Даатгалын тухай хуульд заасан үйл ажиллагаа;

3.1.4. даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийн Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;

3.1.5. хоршооны Хоршооны тухай хуульд заасан хадгаламж, зээлийн үйл ажиллагаа;

3.1.6. хуульд заасан санхүүгийн бусад үйл ажиллагаа.

3.2. Банкны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг банкны тухай хууль тогтоомжоор зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Санхүүгийн зохицуулах хороо, түүний бүрэн эрх, бусад байгууллагатай харилцах

4 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хороо

4.1. Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

4.2. Хорооны дүрмийг Улсын Их Хурал батална.

4.3. Хороо нь эрхлэх асуудлынхаа онцлогийг илэрхийлсэн бэлгэдэлтэй байж болох бөгөөд тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

5 дугаар зүйл. Хорооны үйл ажиллагааны зарчим

5.1. Хороо үйл ажиллагаандаа бие даасан, ил тод байх, бусдын нөлөөнд үл автах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг удирдлага болгоно.

6 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх

6.1. Хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;

6.1.2. бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох;

6.1.3. санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох,

¹ Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Иргэний хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

³ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Даатгалын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2004 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2004 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Хоршооны тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

6.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг шалгах;

6.1.5 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох;

6.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх;

6.1.7. Хорооны ажилтны ёс зүйн дүрмийг баталж, биелэлтэд нь хяналт тавих.

6.2. Хороо энэ хуулийн 6.1-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна үйл ажиллагааныхаа чиглэл тус бүрээр дараахь хуулиудад заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.2.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан;

6.2.2. үнэт цаасны зах зээлд оролцогчийн үйл ажиллагааны чиглэлээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан;

6.2.3. даатгалын үйл ажиллагааны чиглэлээр Даатгалын тухай хуульд заасан;

6.2.4. даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны чиглэлээр Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан;

6.2.5. хадгаламж, зээлийн үйл ажиллагааны чиглэлээр Хоршооны тухай хуульд заасан.

7 дугаар зүйл. Хорооны хуралдаан

7.1. Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

7.2. Хороо сард нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд хуралдааны дэгийг Хороо тогтооно.

7.3. Хоёроос доошгүй гишүүний бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн Хорооны дарга тусгай хуралдааныг зарлан хуралдуулж болно.

7.4. Хорооны гишүүдийн олонхи нь оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

7.5. Хорооны хуралдаанд мэргэжлийн хүмүүсийг урилгаар оролцуулж болно.

7.6. Хорооны хуралдааны явцыг тэмдэглэлээр баталгаажуулах бөгөөд түүнд хуралдаанд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурна.

7.7. Хорооны хуралдаанаар асуудлыг нь хэлэлцэж байгаа хуулийн этгээдэд Хорооны гишүүний гэр бүл, төрөл садангийн хүн ажилладаг бол Хорооны гишүүн хуралдаан эхлэхээс өмнө энэ тухай мэдэгдэж, уг асуудлыг хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргахад оролцохгүй.

8 дугаар зүйл. Хорооны шийдвэр

8.1. Хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд түүнд Хорооны дарга гарын үсэг зурна.

8.2. Бүрэн эрхийнхээ хүрээнд Хорооны гаргасан шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

8.3. Хуралдаанд оролцсон гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

8.4. Хороо нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргахдаа тухайн шийдвэрийн төслийг өөрийн Веб хуудас буюу өдөр тутмын хэвлэлд нийтлүүлэн, тайлбар өгч, санал авч болно.

9 дүгээр зүйл. Хороо Улсын Их Хуралтай харилцах

9.1. Хороо хуулийн хэрэгжилт, түүнчлэн өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааныхаа талаар жил тутам Улсын Их Хуралд тайлагнана.

9.2. Хорооны үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд Улсын Их Хурал зохих бүтцээрээ дамжуулан хяналт тавина.

10 дугаар зүйл. Хороо Монголбанк, Засгийн газартай харилцах

10.1 Хороо санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, түүнийг хөгжүүлэх, зохицуулах, хяналт тавих чиглэлээр өөр хоорондоо уялдсан үйл ажиллагаа явуулах, үр ашгийг нь нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах гурван талт харилцан ойлголцлын санамж бичиг /цаашид "санамж бичиг" гэх/ үйлдэнэ.

10.2 Санамж бичигт санхүүгийн зах зээлийг тогтвортой байлгах талаар Монголбанк, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Хорооны хүлээх үүрэг, харилцан солилцох мэдээлэл зэрэг бусад асуудлыг тусгана.

10.3. Хороо Монголбанк, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай харилцахдаа энэ хуулийн 10.1-д заасан санамж бичгийг удирдлага болгоно.

10.4. Санхүүгийн үйлчилгээтэй холбоотой асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхэд Хорооны дарга зөвлөх эрхтэй оролцож болно.

10.5. Хороо үйл ажиллагааныхаа жилийн тайланг Засгийн газар, Монголбанкинд хүргүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хорооны бүрэлдэхүүн, ажлын алба

11 дүгээр зүйл. Хорооны дарга, гишүүн, түүнийг томилох

11.1. Хороо нь дарга, 6 гишүүнээс бүрдэнэ.

11.2. Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр 1 хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас томилоно.

11.3. Хорооны дарга болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооноос нэр дэвшүүлсэн тус бүр 1 гишүүн орон тооны, бусад дөрвөн гишүүн нь орон тооны бус байна.

11.4. Байнгын хорооноос санал болгох нэр дэвшигч хувийн хэвшлийг төлөөлсөн байж болно.

11.5. Хорооны гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй:

11.5.1. төрийн улс төрийн албан хаагч;

11.5.2. улс төрийн намын удирдах албан тушаалтан;

11.5.3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;

11.5.4. санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдэд ажиллаж байгаа этгээд;

11.5.5. санхүүгийн үйлчилгээ явуулж байгаа хуулийн этгээдийн энгийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч.

11.6. Хорооны дарга, гишүүн нь эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй, Монгол Улсын иргэн байна.

11.7. Хорооны гишүүнд нэр дэвшигчийг Улсын Их Хурал томилоогүй бол энэ хуулийн 11.2-т заасан эрх бүхий этгээд ажлын 14 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд оруулна.

11.8. Хорооны дарга, орон тооны гишүүд төрийн тусгай албан хаагч байна.

12 дугаар зүйл. Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа

12.1. Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байх бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

13 дугаар зүйл. Хорооны дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх

13.1. Улсын Их Хурал дараахь үндэслэлээр Хорооны дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

13.1.1. бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

13.1.2. эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

13.1.3. үүрэгт ажлаасаа чөлөөлүүлэхийг хүсэж өөрөө өргөдөл гаргасан;

13.1.4. энэ хуулийн 11.5-д заасан албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан үндэслэлээр Хорооны дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлүүлэх тухай саналыг түүнийг томилоход нэр дэвшүүлсэн этгээд Улсын Их Хуралд оруулна.

14 дүгээр зүйл. Хорооны дарга, гишүүнийг огцруулах

14.1. Хорооны дарга, гишүүнийг дараахь үндэслэлээр огцруулна:

14.1.1. үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй, эсхүл үүргээ ноцтой буюу удаа дараа зөрчсөн;

14.1.2. эрх бүхий байгууллагаас мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;

14.1.3. гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

14.1.4. энэ хуулийн 11.5-д заасныг зөрчсөн нь томилогдсоных нь дараа илэрсэн.

14.2. Улсын Их Хурал энэ хуулийн 14.1.1, 14.1.4 -д заасан тохиолдолд томилуулахаар нэр дэвшүүлсэн этгээдийн саналыг, 14.1.2, 14.1.3-т заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрийг тус тус үндэслэн Хорооны дарга, гишүүнийг огцруулна.

15 дугаар зүйл. Хорооны дарга, гишүүнийг нөхөн томилох

15.1. Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол энэ хуулийн 11.2-т заасан эрх бүхий этгээд өөр хүнийг нэр дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд оруулна.

15.2. Энэ хуулийн 15.1-д заасны дагуу томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа өмнөх гишүүний томилолтын үлдсэн хугацаатай адил байна.

16 дугаар зүйл. Хорооны даргын бүрэн эрх

16.1. Хорооны дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1. Хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

16.1.2. Хорооны бүрэн эрхэд хамаарах асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох бусад байгууллагатай шууд харилцаж, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан болон Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд Хорооны байр суурийг илэрхийлэх;

16.1.3. Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

16.1.4. Хорооны гишүүний ажил үүргийг хуваарилж, гүйцэтгэлд нь хяналт тавих;

16.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

16.2. Хорооны даргын түр эзгүйд түүний үүргийг Хорооны даргын томилсон гишүүн гүйцэтгэнэ.

16.3. Хорооны дарга нас барсан, эсхүл түүнийг энэ хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасны дагуу чөлөөлсөн, огцруулсан бол түүний үүргийг шинэ даргыг сонгох хүртэл санхүүгийн салбарт хамгийн олон жил ажилласан орон тооны гишүүн гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл. Хорооны дарга, гишүүний үйл ажиллагаа явуулах баталгаа

17.1. Энэ хуулийн 13, 14 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд Хорооны дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх буюу огцруулахыг хориглоно.

17.2. Хорооны дарга болон орон тооны гишүүний цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно. Орон тооны бус гишүүнд урамшуулал олгох журам, урамшууллын хэмжээг Хорооны дүрмээр зохицуулна.

18 дугаар зүйл. Хорооны ажлын алба

18.1. Хороо өөрийн гишүүдэд үүргээ гүйцэтгэхэд нь туслалцаа үзүүлэх, Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах, үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангах чиг үүрэг бүхий ажлын албатай байна.

18.2. Ажлын албаны үйл ажиллагааг Хорооны дүрмээр зохицуулна.

18.3. Ажлын албаны дарга нь Хорооны ерөнхий менежер байх бөгөөд Хорооны ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлж, Хорооноос өгсөн үүргийн биелэлтийг хангана.

18.4. Ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаал төрийн захиргааны албан тушаалд хамаарна.

19 дүгээр зүйл. Дотоод мэдээллийн нууцыг хадгалалх

19.1. Энэ хуулийн 19.2-т зааснаас бусад тохиолдолд Хорооны гишүүн болон ажлын албаны ажилтан Хорооноос дотоод мэдээлэл гэж тогтоосон, нийтэд зориулагдаагүй мэдээг тараах, бусдад мэдээлэх, хувийн зорилгодоо ашиглахыг хориглоно.

19.2. Хорооны гишүүн болон ажлын албаны ажилтан дараахь тохиолдолд энэ хуулийн 19.1-д заасан мэдээллийг Хорооноос тогтоосон журмын дагуу бусдад мэдээлж болно:

19.2.1. энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон

улсын гэрээнд заасны дагуу нууц мэдээгээр хангахыг зөвшөөрсөн;

19.2.2. Монголбанк хүсэлт гаргасан;

19.2.3. санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүсэлт гаргасан;

19.2.4. шүүх, прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага бичгээр хүсэлт гаргасан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хорооны санхүүжилт, нягтлан бодох бүртгэл

20 дугаар зүйл. Хорооны санхүүжилт

20.1. Хорооны санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

20.1.1. улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

20.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс;

20.1.3. хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаас олон бусад орлого.

21 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэл, аудит

21.1. Хороо нь холбогдох хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл

22 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

22.1. Энэ хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо олгоно.

22.2. Бүтцэд нь банк ордог компанийн аливаа хэлбэрийн нэгдлийн гишүүний охин компанид тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэхдээ Монголбанкны саналыг авна.

22.3. Хороо энэ хуулийн 22.2-т заасны дагуу тусгай зөвшөөрөл олгосон бол хяналтыг Монголбанкттай хамтран хэрэгжүүлнэ.

22.4. Хороо тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан компанийн толгой компанийн дүрэм, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг шаардан авч, хянан үзэж болно.

22.5. Санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл

ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Даатгалын тухай хуулийн 18, 19, 20, 69, 70 дугаар зүйл, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 8, 9, 10, 11, 12, 38, 39 дүгээр зүйлд зааснаар зохицуулна.

23 дугаар зүйл. Бүртгэл

23.1. Хорооноос олгосон аливаа зөвшөөрөл, эрхийн бүртгэлийг Хороо хөтөлж, хадгална.

23.2. Энэ хуулийн 23.1-д заасан бүртгэл хөтөлж журмыг Хороо батална.

23.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд тухайн зөвшөөрөл, эрхэд хамаарах үйл ажиллагаа явуулахаа больсон бол энэ тухай Хороонд ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хорооноос тавих хяналт

24 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг хянан шалгах

24.1. Хороо энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Хорооны шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, шалгалт хийнэ.

24.2. Энэ хуулийн 24.1-д заасан хяналт шалгалтыг Хорооны даргын томилсон хянан шалгагч хэрэгжүүлнэ.

24.3. Хорооны хянан шалгагч улсын байцаагчийн эрхтэй байна.

24.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг зөрчсөн гэж Хороо үзвэл хэдийд ч шалгалт хийж болно.

24.5. Хорооны хянан шалгагч энэ хууль болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.1, 19.2, 19.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 37.1, 37.2 дахь заалт, Даатгалын тухай хуулийн 61, 62, 63, 64, 65, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 30, 31, 32, 33, 34 дүгээр зүйлд заасан хяналт шалгалтыг эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

25 дугаар зүйл. Хянан шалгагчийн бүрэн эрх

25.1. Хянан шалгагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн албан ажлын болон үйл ажиллагаа явуулж байгаа байранд ажлын цагаар нэвтрэн орох;

25.1.2. шалгалтад шаардлагатай мэдээ, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

25.1.3. холбогдох баримт бичгийг хянан үзэх, түүнийг хуулбарлуулан авах;

25.1.4. шалгалттай холбоотой асуулт тавьж, хариулт авах;

25.1.5. шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулах;

25.1.6. зөрчлийг арилгах хүртэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох;

25.1.7. хууль тогтоомжийн дагуу захиргааны шийтгэл ногдуулах;

25.1.8. тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжийг ноцтой буюу удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох талаар Хороонд санал оруулах;

25.1.9. шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

25.1.10. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

25.2. Хянан шалгагч нь Хорооноос баталсан удирдамжийн дагуу шалгалт хийх бөгөөд удирдамжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан танилцуулна.

25.3. Шалгалтыг Хорооноос тогтоосон хугацаанд холбогдох этгээдийн өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүйгээр зохион байгуулна.

26 дугаар зүйл. Шалгалтын тайлан

26.1. Шалгалтын тайланд дараахь зүйлийг тусгана:

26.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаархи дүгнэлт;

26.1.2. тайлантай холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хариу шаардах, хариу шаардаагүй бол онцгойлон анхаарах асуудал.

26.2. Хороо шалгалт дууссанаас хойш ажлын 45 хоногийн дотор шалгалтын товч тайланг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

26.3. Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан бол тусгай зөвшөөрөл эзэмшигч тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

27 дугаар зүйл. Хорооны мэдээлэл шаардах эрх

27.1. Хороо буюу Хорооноос эрх олгосон этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл, санхүүгийн болон бусад баримт бичиг гаргаж өгөхийг бичгээр шаардаж болно.

27.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь

компанийн аливаа хэлбэрийн нэгдлийн гишүүн бол Хороо тухайн нэгдэлд багтах аль ч этгээдийн, эсхүл уг нэгдлийн санхүүгийн тайланг шаардаж болно.

27.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 27.1, 27.2-т заасны дагуу Хорооны шаардсан мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж өгнө.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хяналтын зөвлөл

28 дугаар зүйл. Хяналтын зөвлөл

28.1. Хорооны дэргэд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид "Хяналтын зөвлөл" гэх/ ажиллана.

28.2. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурал батална.

28.3. Хяналтын зөвлөл үйл ажиллагааныхаа тайланг дараа оны эхний улиралд Улсын Их Хуралд танилцуулна.

29 дүгээр зүйл. Хяналтын зөвлөлийн гишүүн

29.1. Хяналтын зөвлөл нь дарга, 4 гишүүнээс бүрдэнэ.

29.2. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.

29.3. Хяналтын зөвлөлийн даргад Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн болон Хууль зүйн Байнгын хороо тус бүр хоёр хүний нэр дэвшүүлнэ.

29.4. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, ажлын дадлага туршлагатай, ёс зүйн хувьд төлөвшсөн Монгол Улсын иргэнийг томилно.

29.5. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр төрийн улс төрийн албан хаагч, улс төрийн намын удирдах албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Хорооны дарга, гишүүн болон ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтныг томилохыг хориглоно.

29.6. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг дараахь үндэслэлээр хугацаанаас өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

29.6.1. биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон, эсхүл чөлөөлүүлэхийг хүсэж өөрөө өргөдөл гаргасан;

29.6.2. үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;

29.6.3. гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

29.6.4. ашиг сонирхлын зөрчил үүссэн.

29.7. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг энэ хуулийн 29.6-д зааснаас бусад үндэслэлээр хугацаанаас өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг хориглоно.

30 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн ажлын алба

30.1. Хяналтын зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангах, гишүүдэд чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах, тэднийг шуурхай мэдээллээр хангах, хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулах үүргийг Хорооны ажлын алба гүйцэтгэнэ.

31 дүгээр зүйл. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд олгох урамшуулал

31.1. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд олгох урамшууллын хэмжээг энэ хуулийн 28.2-т заасан журмаар тогтооно.

32 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн шийдвэр

32.1. Хяналтын зөвлөлийн шийдвэр гарах хүртэл Хорооны шийдвэрийн хэрэгжилтийг Хяналтын зөвлөл түр түдгэлзүүлж болно.

32.2. Хяналтын зөвлөлийн хуульд нийцсэн шийдвэрийг Хороо биелүүлэх үүрэгтэй.

32.3. Хяналтын зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

32.4. Хяналтын зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг гомдол гаргагч эс зөвшөөрвөл шүүхэд хандаж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Маргаан шийдвэрлэх

33 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

33.1. Хороо өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэнэ.

33.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч нь Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад

34 дүгээр зүйл. Сэжиг бүхий гүйлгээний талаар мэдээлэх

34.1. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй гэж үзсэн гүйлгээний талаар Хороонд нэн даруй мэдээлнэ.

34.2. Хороо энэ хуулийн 34.1-д заасны дагуу ирүүлсэн мэдээллийг хянаж, шаардлагатай гэж үзвэл эрх бүхий хуулийн байгууллагаар шалгуулах арга хэмжээ авна.

35 дугаар зүйл. Мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээ авах

35.1. Хороо мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг бодлого, арга хэмжээний талаар тавих шаардлага, хориг зэргийг тодорхойлсон журам гаргаж болно.

36 дугаар зүйл. Мөнгө угаах, алан хядах ажиллагааны эсрэг хууль тогтоомжийг биелүүлэх

36.1. Санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх талаархи хууль тогтоомжийг сахин биелүүлэх үүрэг хүлээнэ.

37 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

37.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.8 дахь заалтын "Үнэт цаасны хороо" гэснийг "Санхүүгийн зохицуулах хороо" гэж өөрчилсүгэй.

хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 7.1.3 дахь заалтын "Үнэт цаасны хорооны" гэснийг "Санхүүгийн зохицуулах хорооны" гэж, 8.1.2 дахь заалтын "Үнэт цаасны хорооны дарга" гэснийг "Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зар сурталчилгааны тухай хуулийн 17.2.3 дахь заалтын "Үнэт цаасны хорооноос" гэснийг "Санхүүгийн зохицуулах хорооноос" гэж өөрчилсүгэй.

хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Компанийн тухай хуулийн 13.3, 94.2 дахь хэсгийн "Үнэт цаасны хорооноос" гэснийг "Санхүүгийн зохицуулах хорооноос" гэж, 13.9 дэх хэсгийн "Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу Үнэт цаасны хороонд" гэснийг "Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд" гэж, 43.3 дахь хэсгийн "Үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Үнэт цаасны хороонд" гэснийг "Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд" гэж, 59.1 дэх хэсгийн "Үнэт цаасны хороонд" гэснийг "Санхүүгийн зохицуулах

хороонд" гэж, 18.6, 58.2, 66.2, 93.1, 96.1 дэх хэсэг, 91.7.4, 94.3.4 дэх заалтын "Үнэт цаасны хороо" гэснийг "Санхүүгийн зохицуулах хороо" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1 дэх хэсгийн "Хороо" гэсний дараа "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна" гэж нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 31, 32, 33, 35, 36 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.1.1 дэх заалтын "Үнэт цаасны хороо" гэснийг "Санхүүгийн зохицуулах хороо" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.3 дахь хэсгийн "даатгалын болон", "Санхүүгийн болон", 37.1 дэх хэсгийн "Хорооны гишүүн болон" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хоршооны тухай хуульд дараахь агуулгатай 48¹.4 дэх хэсэг нэмсүгэй:

"48¹.4. Энэ хуулийн 48¹.3 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна."

2 дугаар зүйл. Хоршооны тухай хуулийн 48¹.3 дахь хэсгийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"48¹.3. Хоршоо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос

олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ."

3 дугаар зүйл. Хоршооны тухай хуулийн 8.4 дэх хэсгийн "Төв банк" гэснийг "Санхүүгийн зохицуулах хороо" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨВ БАНК /МОНГОЛБАНКНЫ/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд дараахь агуулгатай 31¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“31¹ дүгээр зүйл. Монголбанкнаас Санхүүгийн зохицуулах хороотой харилцах

1. Монголбанк нь Санхүүгийн зохицуулах хороо болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах гурван талт харилцан ойлголцлын санамж бичиг үйлдэнэ.

2. Монголбанк Санхүүгийн зохицуулах хороотой харилцахдаа энэ хуулийн 31¹ дүгээр зүйлийн 1-д заасан санамж бичгийг удирдлага болгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль

хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3 дахь хэсгийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

“15.3. Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:

15.3.1. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.2. арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх;

15.3.3. даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.4. банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх;

15.3.5. андеррайтер, брокер, дилер, үнэт цаасны арилжаа эрхлэх, түүнчлэн үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулалтын сан,

хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах.”

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.4.1 дэх заалтын “болон арилжааны” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.2.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 2.1 дэх хэсгийн "Банкны тухай хууль" гэснийг "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль" гэж, 3.1, 6.1, 13.4, 14.1, 15.2 дахь хэсэг, 4.1.1, 4.1.10, 8.1.3, 9.1.1, 20.1.3 дахь заалтын "Монголбанкнаас" гэснийг "Санхүүгийн зохицуулах хороонд" гэж, 17 дугаар зүйлийн гарчиг, 8.1, 10.2, 14.5, 15.3, 17.1, 17.2, 18.2 дахь хэсэг, 20.1.6 дахь заалтын "Монголбанкинд" гэснийг "Санхүүгийн зохицуулах хороонд" гэж, 8.2, 9.1, 9.2, 14.2, 14.6, 15.3, 15.5, 18.3, 18.4, 19.1, 19.2, 19.3 дахь хэсгийн "Монголбанк"

гэснийг "Санхүүгийн зохицуулах хороо" гэж, 9.4, 11.3, 18.1, 18.5, 20.1 дэх хэсгийн "Монголбанкны" гэснийг "Санхүүгийн зохицуулах хорооны" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай заалт, хэсэг нэмсүгэй.

1/7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"7.1.6. Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн Төрийн ордны нутаг дэвсгэрт хамаарах хэсэг."

2/13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"13.4. Жагсаал, цуглаанд оролцож байгаа авто хөсгийн хөдөлгөөнийг тусгайлан зохицуулна.

2 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"9.1. Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилгийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ."

3 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "улс төр, олон нийтийн байгууллага" гэснийг "улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага", 8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "зөвшөөрөгдсөн" гэснийг "бүртгэгдсэн", 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "б өдрийн" гэснийг "3 өдрийн", "зөвшөөрсөн" гэснийг "бүртгэсэн", 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "хийхийг зөвшөөрөх" гэснийг "хийх мэдэгдлийг бүртгэх", 9 дүгээр

зүйлийн 6 дахь хэсгийн "даргаас зөвшөөрөл авсны" гэснийг "даргад бүртгүүлсний", 10 дугаар зүйлийн гарчигийг "хийхийг зөвшөөрөхөөс татгалзах" гэснийг "хийх тухай мэдэгдлийг хянах", 10 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсгийн "зөвшөөрөхөөс" гэснийг "бүртгэхээс", 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "олон нийтийн байгууллагаас" гэснийг "төрийн бус байгууллагаас", 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "олон нийтийн байгууллага" гэснийг "төрийн бус байгууллага", 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "зөвшөөрөл авалгүйгээр" гэснийг "бүртгүүлэлгүйгээр", 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "зөвшөөрөл авсан" гэснийг "бүртгүүлсэн", 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "зөвшөөрөлгүй" гэснийг "бүртгүүлэлгүйгээр", "зөвшөөрсөн" гэснийг "бүртгэсэн", 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "зөвшөөрөгдөөгүй буюу зөвшөөрөл авалгүйгээр" гэснийг "бүртгүүлэлгүйгээр", "олон нийтийн байгууллагад" гэснийг "төрийн бус байгууллагад", 15 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн "зөвшөөрөл олоогүйгээс" гэснийг "бүртгээгүйгээс" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "зөвшөөрөгдсөн" гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1 / 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7, 8 дахь заалт:

"7/ "байгаль орчныг хамгаалах" гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчлан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна;

8/ "байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөл" гэдэгт /цаашид "нөхөрлөл" гэх / иргэд тухайн нутаг дэвсгэртээ байгаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, гэрээгээр зохистой ашиглах, эзэмших зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу зохион байгуулагдаж, энэ хуульд зааснаар гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллага хамаарна."

2 / 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"6/ сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дэх хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших."

3 / 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4/ байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх."

4 / 6 дугаар зүйлийн 3,4 дэх хэсэг:

"3. Хууль, гэрээнд заасан журмын дагуу иргэн өмчийн болон эзэмшлийн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газар дээрээ өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ургамал, ойд, өсгөж үржүүлсэн амьтан болон хурын усыг хуримтлуулах замаар байгуулсан усан сан, нуур, цөөрмийг өмчилж болно.

4. Байгалийн баялгийг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу бий болгосон эсэх талаар мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлт, орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тэдгээрт өмчлүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ."

5 / 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11 дэх заалт:

"11 / идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах журам боловсруулан батлах;"

6 / 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

"5/ нутаг дэвсгэрийнхээ байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалалт, ашиглалт, эзэмшлийг энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлд хариуцуулах асуудлыг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн шийдвэрлэх."

7 / 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт:

"7/ энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад заасан шийдвэрийг үндэслэн иргэдийн нөхөрлөлд хариуцуулах байгалийн тодорхой төрлийн баялгаас нь зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих."

8 / 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт:

"7/ нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалалт, ашиглалт, эзэмшлийг хариуцуулах."

9 / 26 дугаар зүйлийн 5, 6, 7, 8 дахь хэсэг:

"5. Байгаль орчны хяналтын улсын байцаагчаар экологи, байгаль хамгаалал, байгаль орчны хяналт, үнэлгээний чиглэлийн мэргэжилтэй, эсхүл энэ чиглэлээр мэргэшиж дадлагдажсан дээд боловсролын зэрэгтэй иргэнийг томилно.

6. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгаль орчны чиглэлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сургуулийн мэргэжлийн сургалтад хамрагдаж төгссөн иргэнийг байгаль хамгаалагчаар ажиллуулна.

7. Нэг байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн хэмжээ нь өндөр уулын бүсэд 100.0, ойт хээрийн бүсэд 120.0, тал хээрийн бүсэд 500.0, цөлөрхөг хээрийн бүсэд 600.0, цөлийн бүсэд 800.0 мянга хүртэл га, улсын төсвийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ойн зурваст 30 км тутамд нэг байгаль хамгаалагч байх ба энэ нормативийг хот орчмын ногоон бүсэд 70 хувиар багасгаж тооцно. Тухайн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт, дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт нэг байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээг тухайн тусгай хамгаалалттай газрын ангилал, хамгаалах дэглэм, онцлог, ачаалал зэргийг харгалзан Засгийн газар тогтооно.

8. Тухайн орон нутагт байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий идэвхтэн байгаль хамгаалагчийг



томилон ажиллуулж болно.”

10/ 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт:

“6/ байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах.”

11 / 29¹ дүгээр зүйл :

“29¹ дүгээр зүйл. Улсын байцаагч, байгаль хамгаалагчийн нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх баталгаа.

1. Улсын байцаагч, байгаль хамгаалагч нь нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх дараахь баталгаагаар хангагдана:

1/ төрийн албанд 25 ба түүнээс дээш жил, түүнээс сүүлийн 10 жилийг нь байгаль хамгаалах албанд ажилласан байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарыг тэтгэвэрт гарахад нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа байгууллагаас нь нэг удаа олгох;

2/ ажил үүргээ гүйцэтгэх зориулалтаар унаа, дүрэмт хувцас, галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэлээр хангагдах.

2. Улсын байцаагч, байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа бусдын нөлөөгөөр хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт нь дараахь буцалтгүй тусламж, цалингийн зөрүүг олгоно:

1/ хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлэгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг ;

2/ хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг;

3/ амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь хохирогчийн 3 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж;

4/ энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндсэн цалингийн зөрүү, буцалтгүй тусламжийг төсвөөс олгож, түүнтэй тэнцэх хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

5/ хуульд заасан бусад баталгаа.”

12/ 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2. Мэргэжлийн байгууллагад энэ зүйлийн 1дэх хэсэгт заасан үйл ажиллагааг эрхлэн зохицуулах эрх олгох журмыг Засгийн газар батална.”

13 / 31¹ дүгээр зүйл :

“31¹ дүгээр зүйл. Нөхөрлөл

1. Байгаль орчныг хамгаалах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдан оролцож болох бөгөөд гэрээний үндсэн дээр хамгаалахаар хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ

байгалийн тодорхой төрлийн баялгийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу зохистой ашиглах, эзэмших давуу эрхтэй байна.

2. Нөхөрлөлийн гишүүн нь 18 нас хүрсэн, тухайн сум, дүүргийн харьяат, мөн сум, дүүрэгтээ байнга оршин суугч Монгол Улсын иргэн байна.

3. Байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар нөхөрлөлийн баримтлах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмыг үндэслэн нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар байгаль хамгаалах чиглэлээр явуулах үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэж батална.

5. Байгалийн тодорхой төрлийн баялгийг гэрээний дагуу нөхөрлөлд хариуцуулахдаа нөхөрлөлийн гишүүдийн тоо, хариуцуулах талбай, баялгийн нөөц хэмжээ, онцлог зэргийг харгалзана.

6. Нөхөрлөлд хариуцуулах байгалийн баялагт газарт түүний хэвлийн баялаг, бэлчээр, усан сан бүхий газар, тусгай хэрэгцээний газар хамаарахгүй.

7. Байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах тухай иргэдийн нөхөрлөлийн хүсэлтийг шийдвэрлэх асуудлыг дараахь баримт бичгийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга зохион байгуулна:

1/ баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр;

2/ нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг хүссэн өргөдөл;

3/ нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан байгаль хамгаалах чиглэлээр явуулах үйл ажиллагааны хөтөлбөр;

4/ нөхөрлөл байгуулсан гишүүдийн хамтран ажиллах тухай гэрээний хуулбар;

5/ нөхөрлөлийн гишүүдийн иргэний үнэмлэхийн хуулбар.

8. Ирүүлсэн баримт бичиг нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлага, энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан бүрдэл, мөн зүйлийн 3 дахь хэсгийн дагуу баталсан журмын нөхцөлийг хангасан, баримт бичиг бүрэн бол сум, дүүргийн Засаг дарга нөхөрлөлийн хүсэлтийг хүлээн авч байгаа хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах тухай гэрээ байгуулж, гэрчилгээ олгоно.

9. Нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээ болон гэрчилгээний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10. Нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр явуулах үйл ажиллагааг дараахь тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга зогсоож, гэрээг цуцлана:

1/ нөхөрлөлийн байгаль хамгаалах

чиглэлээр явуулах үйл ажиллагааг зогсоох тухай баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гарсан;

2/ энэ зүйлийн 11 дэх хэсэг болон гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, гэрээ байгуулснаас эхлэн 6 сар байгаль хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа явуулаагүй;

3/ бүх гишүүдийн хурлаар нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр явуулах үйл ажиллагааг зогсоох талаар шийдвэр гарсан;

4/ энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг зөрчсөн.

11. Нөхөрлөл нь энэ хуулийн 31 дүгээр зүйл, байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, ашиглах, эзэмших харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжид заасан үүргийг биелүүлэхийн зэрэгцээ, тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээнд заасны дагуу өөрийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн эрхлэнэ.

12. Нөхөрлөл нь жил бүр сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд байгаль хамгаалах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн биелэлтийг танилцуулж, тайлан тавьж байна.

14 / 34 дүгээр зүйлийн 4, 5, 6, 7 дахь хэсэг:

"4. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга олгоно.

5. Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн улсын байцаагчид мэргэжлийн хяналтын байгууллага, байгаль хамгаалагчид тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга олгоно.

6. Энэ зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан урамшуулал олгох журмыг Сангийн болон Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална.

7. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан мэдээлэгчид холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцлана."

15 / 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4/ энэ хуулийн 37 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гам буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаагүй албан тушаалтныг 30000 - 60000 төгрөгөөр торгох."

16 / 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Улсын байцаагч, байгаль хамгаалагчийн хууль ёсны шаардлагыг зориуд үл биелүүлсэн, биелүүлэхгүй байхыг уриалсан, эсэргүүцсэн, албан

үүргээ биелүүлэхэд нь санаатай саад учруулсан, албан үүрэгтэй нь холбогдуулан улсын байцаагч, байгаль хамгаалагч болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг доромжилсон, гүтгэсэн, заналхийлсэн, хүч хэрэглэсэн этгээдэд Эрүүгийн хууль болон Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ."

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын " олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх" гэсний дараа " нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх"; 14 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "хягаарлах" гэсний дараа "буюу тодорхой хугацаагаар хориглох"; 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын " иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах" гэсний дараа " биологийн болон генетикийн нөөцийг тогтвортой ашиглахад чиглэгдсэн уламжлалт мэдлэг, шинэ санаа, амьдралын туршлагыг хэрэглэснээр гарах үр ашгийг тэгш, шударгаар ашиглах явдлыг дэмжих"; 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтын "ялгах тэмдэг" гэсний дараа " дүрэмт хувцас"; 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "хортой" гэсний дараа " аюултай"; 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтын "хоргүй, гэсний дараа "аюулгүй"; 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын "даацын" гэсний дараа "болон нөөцийн ашиглалтын"; 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "1 дэх хэсгийн 1," гэсний дараа "2."; 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтын "эрхийг хүчингүй болгуулах" гэсний дараа "үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоох"; 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын "өгөх" гэсний дараа " хяналт тавих"; 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "ашиглах" гэсний дараа " нөхөн сэргээх "; 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "олон нийтийн байгууллагад" гэсний дараа " эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан этгээдэд."; 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "ашигласан" гэсний дараа "болон зөвшөөрөлгүй агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон"; 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "буюу" гэсний дараа "байгаль орчны хяналтын"; 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын "энэ хуулийн" гэсний дараа "21 дүгээр зүйлийн 3," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1,3 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1 / 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1, 3 дахь заалт:

"1/ үнэлгээний багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь орон тооны мэргэжлийн боловсон хүчин байх;

3/ магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаас батлагдсан байгаль орчны үнэлгээ хийх арга зүйтэй байх;

2/31 дүгээр зүйлийн 4 дэх заалт:

"4/ байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаанаах ааа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх;"

4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "улсын мэдээллийн төв санд" гэснийг "улсын нэгдсэн мэдээллийн санд"; 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "11" гэснийг "12"; 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "хорт" гэснийг "хортой, аюултай"; 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "хортой" гэснийг "сөрөг"; 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "хорт бодис гаргасан, хортой" гэснийг "сөрөг"; 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "химийн хорт бодис" гэснийг "химийн хортой, аюултай бодис, тэдгээрийг агуулсан нэгдлийг"; 26 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4 дэх заалтын "Зэсийн газраас тогтоосон" гэснийг "энэ хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан"; 30 дугаар зүйлийн "2" дахь хэсгийн дугаарыг

"3"; 32 дугаар зүйлийн гарчиг, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн " олон нийтийн" гэснийг " төрийн бус"; 37 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "төлүүлэхээр шүүхэд нэхэмжилж болно." гэснийг "төлүүлэхээр сум, дүүргийн Засаг дарга шүүхэд нэхэмжлэл гаргана."; 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын "50000-100000" гэснийг "100000-200000"; мөн хэсгийн 2 дахь заалтын "10000-20000" гэснийг "20000-40000", "75000-150000" гэснийг "150000-250000"; мөн хэсгийн 3 дахь заалтын "10000-25000" гэснийг "20000-50000", "150000-200000" гэснийг "200000-250000" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтын "байгаль орчныг хамгаалах талаар төрийн хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах"; 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "шаардлагатай бол"; 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтын "галын"; 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтын " Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага уг шийдвэрийг үл зөвшөөрөл гомдлоо шүүхэд гаргана"; гэснийг тус тус хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСАД АМЬДАРЧ БУЙ ОХУ-ЫН ЦАГААЧ ИРГЭДЭД ЭЗЭМШИЖ БАЙГАА ОРОН СУУЦЫГ НЬ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХУВЬЧЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсад амьдарч буй ОХУ-ын цагаач иргэдэд эзэмшиж байгаа орон сууцыг нь үнэ төлбөргүй хувьчлах тухай Монгол Улсын Гадаад хэргийн яамны 2003 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн А-2003/622 тоот ноот бичиг болон ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны 2003 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 105 тоот ноот

бичгийг Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр гэж үзэн түүнийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2006-2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг 1 дүгээр хавсралтаар, Үндсэн чиглэлийн хүрээнд 2006 онд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2006-2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн зорилтыг Улсын Их Хурлаас батлан гаргасан бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөрүүдтэй уялдуулан, цаг хугацаанд нь төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар

/Ц.Элбэгдорж/, Монголбанк /О.Чулуунбат/-д даалгасугай.

3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2006-2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, түүний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийн явцын талаар 2006 оны 10 дугаар сард, хэрэгжилтийг 2007 оны 1 дүгээр улиралд багтаан тус тус Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ц.Элбэгдорж/, Монголбанк /О.Чулуунбат/-д, дэвшүүлсэн хяналт зохих түвшинд хэрэгжиж байгаа эсэхэд эрх ялалт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо болон холбогдох бусад Байнгын хорооны дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2006-2008 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| д/д | Хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэл | Хэмжих шалгуур үзүүлэлт | 2006 оны нэрлэлт | | Төсөвөлөл |
|-----|--|---|---------------------|------------|------------|
| | | | 2007 | 2008 | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | Бүлэг 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ТЭНЦВЭР, ОСОЛТ | | | | |
| | Зорилт. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах орчныг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг тогтворжуулна: | ДНБ-ний өсөлт /хувийр/ | 7.6 | 6.7 | 6.7 |
| 1 | инфляцийг зохистой түвшинд байлгах бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх; | хэрэглээний үнийн индекс /хувийр/ | 6.0-7.0 | 6.0-6.5 | 6.0-6.5 |
| 2 | валютын ханшны огцом өөрчлөлтөөс сэргийлж, гадаад валютын нөөцийг зохистой удирдах; | төгрөг болон ам.долларын харьцах ханшийн жилийн өөрчлөлт /хувийр/ | 2.3 | 2.4 | 2.2 |
| 3 | банк, санхүүгийн салбарыг бэхжүүлэх, санхүүгийн зах зээлд төрийн оролцоог бууруулж, санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих; | төрийн өмч оролцсон банкны тоо | 2 | 1 | 1 |
| 4 | урт хугацаанд гадаад, дотоод ерийн тогтвортой байдлыг хангах үүднээс "Гадаад ерийн талаар баримтлах стратеги" боловсруулан, өрийг Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр зохицуулан шийдвэрлэж байх; | ДНБ-нд гадаад ерийн эзлэх дээд хязгаар /хувийр/ | 80.0 | 80.0 | 80.0 |
| 5 | гадаад худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлж, экспортод гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан, экспортыг нэмэгдүүлэх; | ДНБ-д эзлэх экспортын хэмжээ /хувийр/ | 53.0 | 56.0 | 59.0 |
| 6 | гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хамгаалах таатай орчин бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах; | гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ /сая ам.доллараар/ | 115.0 | 120.0 | 125.0 |
| 7 | ДНБ-д эзлэх төсвийн орлого, зөрлөгийн зохистой харьцааг хангаж, улмаар төсвийн алдагдлыг бууруулах; | ДНБ-нд эзлэх улсын төсвийн алдагдал /хувийр/ | -3.5 | -1.1 | 1.4 |
| 8 | төсвийн болон зээл тусламжийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрийн дагуу хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх; | Хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлагдсан байх | - | - | - |

| Бүлэг 2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРЫН БОДЛОГО | Зорилт. ДНБ-нд боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эзлэх хувийг нэмэгдүүлж, төрөлжилтийг гүнзгийрүүлнэ; | ДНБ-нд эзлэх хувь | 61.5 | 63.6 | 65.9 |
|---|--|--|-------|-------|-------|
| 9 | эрчим хүчний хүрэлцээ хангамжийг сайжруулж, цахилгаан, эрчим хүчний байнгын эх үүсвэртэй ерхийн тоог бууруулах; | нэгдсэн системд холбогдох боломжтой болон холбогдсон сумдын тооны харьцаа /хувиар/ | 61.5 | 65.4 | 69.2 |
| 10 | эрчим хүчний үйлдвэрлэлийг эдийн засгийн төлөвлөсөн өсөлтийг хангахуйц хэмжээнд эрчимтэй хөгжүүлэх; | цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн өсөлт /хувиар/ | 8.6 | 7.7 | 7.7 |
| 11 | сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх; | хөтөлбөрийн хэрэгжилтээр | - | - | - |
| 12 | уул, уурхайн олборлох аж үйлдвэрлэлийн шинэ хүчин чадлыг бий болгохын зэрэгцээ, энэ салбарын бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх; | цэвэр эс үйлдвэрлэл, эсийн баяжмал үйлдвэрлэлийн харьцаа /дахин/ | 1.7 | 1.8 | 1.9 |
| 13 | эрүүл ахуйн шаардлага хангасан хүсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хүн амын хүнсний хангамжийг сайжруулах; | дотоодын үйлдвэрлэлээр хангах гурил /хувиар/ | 25.0 | 32.0 | 40.0 |
| | | дотоодын үйлдвэрлэлээр хангах төмс, хүнсний ногоо /хувиар/ | 54.4 | 60.0 | 70.0 |
| | | үйлдвэрлэлийн аргаар боловсруулах сүүний хэмжээ /сая литр/ | 7.0 | 7.7 | 8.5 |
| 14 | Хөдөө аж ахуйг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, байгалийн аливаа эрсдэлээс хамгаалах, хөдөөд хүмүүс тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх; | үйлдвэрлэлийн аргаар боловсруулах махны хэмжээ /мян тонн/ | 13.9 | 15.0 | 16.0 |
| | | тусгаартай нөхцөлд тариалах тариалангийн талбайн хэмжээ /мян. га/ | 16.8 | 18.5 | 20.3 |
| | | цөм сүргийн малын тоо /мян. толгой/ | 918.0 | 936.0 | 954.0 |
| | | Фермерийн аж ахуйн тоо | 375 | 460 | 530 |
| | | услын хэмжээнд хураан авах тээвэрлэлийн ургамлын хэмжээ /тн/ | 2300 | 2400 | 2500 |

| | | 920.0 | 970.0 | 1100.0 | |
|----|---|---|--------------------------------------|--------------------------------------|---------------------------------------|
| 15 | "Цахим Монгол" хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлж, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх. | улсын хэмжээнд бэлтгэх байгалийн хадлан /мян.тн/ бага оврын техник, усалгааны тоног төхөөрөмжөөр хангагдах өрх, аж ахуйн нэгжийн тоо нийт суурин телефон хэрэглэгчийн тоо /мян.шир/ нийт үүрэн телефон хэрэглэгчийн тоо /мян. шир/ интернетийн үйлчилгээ эрхэлдэг цэгийн тоо бэлтгэх програм хангамжийн мэргэжилтэн /хүний тоо/ | 450 165.4 640.3 120 1400 | 800 162.9 720.5 120 1700 | 1200 162.9 759.0 120 1900 |
| | Бүлэг 3. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН САЛБАР | | | | |
| | Зорилт - Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийн хувийг бууруулна: | Нийт хүн амд ядуучуудын тоо /хувиар/ | 33.5 | 31.8 | |
| 16 | ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах; | Ажилгүйдлийн түвшин /хувиар/ | 3.4 | 3.4 | |
| 17 | сургууль завсардалтыг бууруулж, бүх хүүхдэд бага боловсрол олгох зорилтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх; | суурь боловсролын хамралт /хувиар/ | 94.1 | 94.5 | |
| 18 | ерөнхий боловсролын сургалтыг 2006 оноос 11 жилийн тогтолцоонд шилжүүлэх; | 11 жилээр төгсөлт хийх | | | |
| 19 | ерөнхий боловсролын сургуулийн суралцах орчин, нөхцөл, анги танхим, багш нарын болон сурах бичгийн хуралцээ, хангамжийг сайжруулах; | жи-цэгийн байрны суудлын тоо, /мян суудал/ | 324.9 | 328.6 | |
| 20 | бага, дунд сургуульд элсэгчид болон бичиг үсэг тайлагдсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэнцвэргүй байдлыг багасгах; | 15-авс дээш насныхны бичиг үсэг тайлагдсан байдал /охид хөвгүүдийн харьцаа/ | - | 1.0 | |
| 21 | тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах; | 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдэл /тоо/ | 28.0 | | |
| 22 | нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжийг нэмэгдүүлж, эхийн эндэгдлийг бууруулах; | 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл | 95.0 | | |
| 23 | сүрьеэ өвчний тархалтыг бууруулах; | 100 000 хүнд ногдох сүрьеэ өвчнөөр өвчлөгчид /тоо/ | 80 | | |
| 24 | терийн болон хувийн өмчит эмнэлгийн оношлогоо, эмчилгээний чадавхийг сайжруулж, орчин үеийн иж бүрэн оношлогооны төвийг нийслэл болон бүсийн төвүүдэд байгуулах санаачилгыг дэмжих; | үйл ажиллагааны үр дүнгээр | | | |

| | | | | |
|--|---|-------|-------|-------|
| 25 | эмнэлтийн бүх түвшний удирдлагын чадварийг сайжруулан, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах; | 40 | - | 80 |
| 26 | иргэдийн орон байрны хүрэлцээ, хангамж, нөхцөлийг мэдэгдэхүйц сайжруулж, гэр хорооллын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр "40000 орон сууц" хөтөлбөрийн хэрэгжүүлэх; | 10.0 | 10.0 | 10.0 |
| 27 | хүн амын хэт төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч байгаа сөрөг үзэгдлийг багасгаж, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх; | 10.0 | 10.0 | 10.0 |
| 28 | нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр "Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг"-т дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах | 691.1 | 698.3 | 705.6 |
| Бүлэг 4. БАЙГАЛЬ ОРЧИН Зорилт. Байгаль орчны бохирдлыг бууруулах, байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, иргэд экологийн аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ: | | | | |
| 29 | иргэд экологийн хувьд аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг хангах, хотуудын агаарын бохирдлыг багасгах; | 0.4 | 0.3 | 0.2 |
| 30 | байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх, байгалийн нөөцийн нөхөн сэргээлт, хамгаалалтыг сайжруулах; | 200 | 250 | 300 |
| 31 | баталгаат үндэсн ус хэрэглэх боломжгүй хүн амын эзлэх хувийг бууруулах; | 45 | 47 | 49 |
| 32 | байгаль, цэг уурин гамшигт үзэгдлээс ард иргэд, мал сүргийг хамгаалах, урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, малчин өрх болон нийт эдийн засагт учирч байгаа хохирлыг бууруулах; | 13.6 | 13.9 | 14.2 |
| | | 8.22 | 8.23 | 8.24 |
| | | 6.3 | 10.0 | 12.0 |
| | | 44.8 | 45.0 | 45.2 |
| | | 32.0 | 34.5 | 36.0 |
| | | 89.5 | 89.8 | 90.0 |

| | | |
|----|---|--|
| | | |
| 33 | <p>Бүлэг 5. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙ, БАТЛАН ХАМГАЛАХ, ГАДААД БОДЛОГО</p> <p>Зорилт. Засаглалын ил тод байдал, үр дүнг сайжруулж, төрийн үйлчилгээг иргэн бүрт хүргэнэ: иргэд мэдээллийг чөлөөтэй олж авах эрх зүйн болон бусад боломж, нөхцөлийг бүрдүүлэх;</p> | <p>олон сувагар мэдээлэл хүлээн авах боломжтой өрх /дүнд эзлэх хувиар/</p> |
| 34 | <p>цэргийн шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлж, цэргийн байгуулалтыг боловсронгуй болгон, Зөвсэгт хүчний чадавхийг дээшлүүлэн, ИУБ-ийн энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд Монгол Улсын зөвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэх;</p> | <p>үйл ажиллагааны үр дүнгээр</p> |
| 35 | <p>хууль тогтоомж, стандартын биелэлтэд тавих мэргэжлийн хяналт, шалгалтыг чанаржуулж, иргэдэд үйлчлэх үйлчилгээний төрөл болгох;</p> | <p>үйл ажиллагааны үр дүнгээр</p> |
| 36 | <p>иргэдийг гэмт калдлагаас хамгаалах, гэмт хэргийг үнэн зөв шийдвэрлэн, хохирлыг бэрэгдүүлэх, хууль хяналтын байгууллагыг бэхжүүлэх;</p> | <p>гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт сайжирсан байх</p> |
| 37 | <p>эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх улс төр, аюулгүй байдал, эрх зүйн гадаад таатай орчныг бүрдүүлэх;</p> | <p>үйл ажиллагааны үр дүн</p> |
| 38 | <p>"Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-д тусгагдсан зорилтыг хэрэгжүүлж, төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн газруудыг цаашид улсын эдийн засагт илүү хувь нэмэр оруулахуйц байдлаар хувьчилж, өөрчлөн байгуулах.</p> | <p>үндсэн чиглэлийн хэрэгжилт /хувиар/</p> |
| 39 | <p>"Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн хүрээнд хууль болон эрх зүйн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргээмжтэй, хөнгөн шуурхай болгох;</p> | <p>үндсэн чиглэлийн хэрэгжилт /хувиар/</p> |
| 40 | <p>иргэдэд тулгуурласан гамшгаас хамгаалах ажиллагааны менежментийн тогтолцоог бий болгож, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг бэхжүүлэх;</p> | <p>тогтолцоо бий болсон байх</p> |
| 41 | <p>гамшгаас хамгаалах боловсролыг иргэдэд олгох, гадаад хөриццээ, хамтын ажиллагааг өргөжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх;</p> | <p>үйл ажиллагааны үр дүнгээр</p> |
| 42 | <p>шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх;</p> | <p>шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо /хувиар/</p> |
| 43 | <p>Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв болон бусад албадын мэдээлэл солилцох хүчин чадлыг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй болгох.</p> | <p>үйл ажиллагааны үр дүнгээр</p> |

УИХ-ын 2005 оны 67 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2006-2008 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД 2006 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Нэг. Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлого

1.1. Эх орны түүхий эдийн нөөцөд тулгуурлан өргөн хэрэглээний болон хүнсний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

1.2. "Чацаргана" хөтөлбөр боловсруулан 2006 оноос хэрэгжүүлж, энэ хүрээнд хувийн хэвшилд тулгуурлан 2006-2008 онуудад 1.5 – 2.5 мянган ажлын байр бий болгоно.

1.3. Говь, хээрийн бүсийн түлшний асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хүрээнд сэргээгдэх эрчим хүч болон орон нутгийн зарим нүүрсний ордыг ашиглахад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

1.4. Зам, гүүр зэрэг томоохон байгууламжийг эргэж төлөгдөх эзэлийн нөхцөлтэйгээр хувийн хэвшлийн хөрөнгөөр барих ажлыг хэрэгжүүлнэ. Тухайлбал: Улаанбаатар – Эрдэнэсантын хатуу хүчилтгэй замыг шинэчилнэ.

1.5. Дулааны алдагдлыг багасгах зорилгоор орчин үеийн шинэ технологи, материалыг нэвтрүүлэх зорилт тавьж ажиллана.

1.6. Төмөр замын тээврийн салбарт дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1.6.1. төмөр замын эрх зүйн орчныг шинэчилж, өмчийн олон хэлбэрт шилжүүлэх;

1.6.2. шинээр ашиглах ашигт малтмалын орд газруудад төмөр зам барих хөтөлбөр боловсруулах, хайгуул төслийн ажлуудыг гүйцэтгэх;

1.6.3. төмөр замыг цахилгаанжуулах, авто хориголлоор тоноглох судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх;

1.6.4. төмөр замын одоогийн сүлжээний нэвтрүүлэх, боловсруулах чадварыг өсгөх, хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх, зүтгүүр, вагоны засварын баазыг сайжруулах.

1.7. Төвийн бүсийн харилцаа, холбоо, мэдээллийн сүлжээг шинэчлэн, сайжруулна.

1.8. Улаанбаатар хотын захын хороо, Жаргалант, Гачуурт, Баянхошуу зэрэг алслагдсан дүүргүүдийг хөдөлгөөнт холбоо, телевизийн найдвартай сүлжээгээр хангана.

1.9. Нийслэл болон төв суурин газруудын захын гэр хорооллын цахилгаан, дулаан, цэвэр усны хангамжийг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Баянхошуу – Ханын материалын үйлдвэрийн орчин, Баянзүрх дүүргийн Шархад, Хан-Уул дүүргийн Яармагийн хорооллыг дулааны төвлөрсөн шугамд холбох, 110 кВ-ын 2 дэд өртөөг өргөтгөх, тэр хорооллын 3 мянгаас доошгүй айл өрхийг цахилгааны шугамд холбож, нийслэлийн дэд бүцэтийг сайжруулна.

1.10. Шүлхий өвчний оношлуур, вакцины туршилт, судалгаа хийх, дотооддоо үйлдвэрлэх бэлтгэлийг хангах.

Хоёр. Хүний хөгжил, нийгмийн салбар

2.1. 2006 онд хөдөө аж ахуйн салбарт 10.0 мянга, уул уурхай, боловсруулах болон жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарт 32.5 мянга, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт 5.0 мянга, зам, тээвэр, холбоо, аялал жуулчлалын салбарт 1.5 мянга, нийтдээ 50.0 мянга орчим ажлын байрыг шинээр бий болгоно.

2.2. Тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүүг ойртуулахад улсын төсвөөс 22.5 тэрбум төгрөгийг зарцуулж, тодорхой арга хэмжээ авна.

2.3. Говийн болон нийслэлээс алслагдсан аймаг, сумдын эмч, багш нарын тогтвор суурьшлыг сайжруулахын тулд бүсийн нэмэгдэл огтох талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.4. Архи, тамхины онцгой татварын тодорхой хувиар "Эрүүл мэндийг дэмжих сан" байгуулж ажиллуулна.

2.5. Жилд нэг удаа хүн амын эрүүл мэндийн үзлэг хийх сан байгуулж, нийт хүн амыг эрүүл мэндийн үзлэгт хамруулна.

2.6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр-ийг батлан хэрэгжүүлнэ. Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн сурталчилгааны ажлыг олон нийтийн дунд зохион байгуулна.

2.7. Арван долоон аймгийн 102 сумын төв, хөдөөгийн малчдын үндны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулан хүн амыг стандартын шаардлагад нийцсэн усаар хангана.

2.8. Сургалтын төрийн сангийн тогтолцоо, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгож, сургалтын эзэлийн үр ашгийг дээшлүүлнэ.

2.9. Ерөнхий боловсролын сургуулиудыг сургалтын компьютерээр хангах арга хэмжээ авна.

2.10. Мэргэжлийн сургалтын хөтөлбөр, стандартыг төгөлдөржүүлж, хөдөө орон нутагт хувийн хэвшлийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах иргэдийн үүсгэл санаачлагыг дэмжих, тэдгээрийг шинээр байгуулах, өргөтгөх замаар мэргэжилтэй ажилчдын тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.

2.11. Мэргэжлийн сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулж, мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ.

2.12. Шинжлэх ухааны байгууллагуудын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар шинжилгээ, судалгааны ажлын үр өгөөжийг дээшлүүлнэ.

2.13 Дөчөөс тавин таван насны иргэдийг ажлын байраар хангах хөтөлбөр боловсруулж, тусгайлан анхаарч ажиллана.

2.14. Улаанбаатар – Эрдэнэт - Дарханы дэд бүтэц бүхий бүс нутагт фермерийн аж ахуйг төвлөрүүлэн хөгжүүлж 45-аас дээш насны хүмүүсийг ажлын байртай болгоно.

2.15. Улаанбаатар хотод ахмадын нийтийн орон сууц барьж, 200-аас доошгүй ахмад настныг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулна.

2.16. Хүн амд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлыг бүх талаар дэмжиж, бүсийн төвүүдэд спортын цогцолбор, сумдад соёл, спортын төв барьж, үндэсний бөх, морь, сурын спортыг уламжлал, шинэчлэлийг хослуулан хөгжүүлж, нийслэлд олимпын цогцолбор байгуулах санаачлагыг дэмжинэ.

Гурав. Бүс нутгийн хөгжил

3.1. Мянганы замын босоо тэнхлэгийн УБ-Мандагловь-Оюутолгойн чиглэлд хатуу хучилттай замын ажлыг эхлүүлнэ.

3.2. Бүсийн тулгуур төв хотуудын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг өргөтгөх, аймаг, хотын цэвэрлэх байгууламжуудын үйл ажиллагааг сэргээн засварлахад хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг зарцуулна.

3.3. Бүсийн төвүүдийг хөгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусгана.

3.4. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг бүсүүдэд шинээр байгуулж, сургалтын тоног төхөөрөмжөөр хангаж мэргэжилтэй ажилчид бэлтгэнэ.

3.5. Бүсүүдийн нөөц, давуу талыг нээж, зах зээлд бүрэн үр ашигтай ашиглахад чиглэгдсэн зорилтот хөтөлбөр боловсруулан улсын нэгдсэн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

3.6. Бүсүүдийн тулгуур төвүүдэд түшиглэн эдийн засгийн өсөлтийг түргэтгэхэд улсын хөрөнгө оруулалтын дэмжлэгийг түлхүү чиглүүлнэ.

3.7. Тулгуур төвүүдийн эзх зээлд хөдөө, орон нутгийг холбож, бүс нутгийн нөөцийг хоршин

ашиглах үйлдвэрлэл, нийгмийн дэд бүтцийн үндсэн сүлжээг бүрдүүлнэ.

3.8. Эдийн засгийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эхлүүлэхэд онцгой анхаарч ажиллана.

Дөрөв. Байгаль орчин

4.1. Байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийн талаар иргэдийн хариуцлага, эрх үүргийг өндөржүүлэх, байгалийг байнгын эзэмшил, тордолт, хараа хяналттай болгон орон нутгийн хүн амд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлэх арга хэмжээ авна.

4.2. Ойжуулалтын ажлын цар хүрээг өргөжүүлж, арчиглаа, хамгаалалтыг сайжруулах, энэ чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авна.

4.3. Гадаргын усны нөөцийг зохистой ашиглах, гол горхины тэжээгдлийг сайжруулах, усны хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлнэ, түүнчлэн худаг гаргах, засварлах ажлыг эрчимжүүлж, бэлчээрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

4.4. Байгаль экологийн тэнцлийг хангахад онцгой ач холбогдол бүхий газруудыг тусгай хамгаалалтад авч, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.5. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, ялангуяа мазалай зэрэг ховор, нэн ховор амьтныг хамгаалах, генфондыг нь хадгалах, өсгөн үржүүлэх арга хэмжээ авна.

Тав. Засаглал, эрх зүйн салбар

5.1. Онцгой байдлын ерөнхий газрын мэдэлд байгалийн гамшиг, хүн, малын халдварт өвчнөөс үрэдчилэн сэргийлэх, хамгаалах зориулалттай нөөц бий болгоно.

5.2. Сайн засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлж, яам, агентлагийн бүтэц, орон тоог хянаж, удирдлагын зардлыг хямдруулна.

5.3. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын, ялангуяа сумдын Засаг даргын тамгын газрын байрыг засварлаж, төрийн албан хаагчдын ажлын байрны нөхцөл, тогтвор суурьшлыг сайжруулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2006 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2006 онд баримтлах үндсэн чиглэлийг хэвсрэлтээр баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дунь улрал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк /О.Чулуунбат/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

УИХ-ын 2005 оны 68 дугаар
тогтоолын хаесралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2006 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Төрөөс мөнгөний бодлогын талаар дараахь үндсэн чиглэлийг баримтална:

1. Шатахууны үнэ хэт өсөхгүй тохиолдолд хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийг жилийн 7 хувьд байлгана.

2. Зээлийн хүүгийн бүтцийг нарийвчлан судалсны үндсэн дээр заавал байлгах нөөцийн хэмжээ, хүүгийн бодлого, хүүгийн зөрүүгийн хяналт зэрэг аргуудыг хэрэгжүүлж, хүүг бууруулах арга хэмжээ авна.

3. Спортыг дэмжих, хөрөнгө оруулалтын зээл, санхүүгийн түрээсийн зах зээлийг хөгжүүлэх эрх зүй болон эдийн засгийн орчин бүрдүүлж, ажлын байр бий болгох хөтөлбөрийг санхүүжүүлэх бодлогыг дэмжинэ.

4. Санхүүгийн гэрээ, хэлцлийн хугацааг уртасган, санхүүгийн зуучлал явуулж байгаа этгээдэд нэгдсэн байдлаар хяналт тавих тогтолцоо бүрдүүлэн, банк, санхүүгийн салбарын тогтворжилтыг үргэлжлүүлэн гүнзгийрүүлнэ.

5. Гадаад зах зээлээс урт хугацааны санхүүгийн эх үүсвэр татах замаар хөрөнгө оруулалт, худалдааг идэвхжүүлэх арга хэмжээ авна.

6. Нийгмийн чухал ач холбогдол бүхий ипотекийн зах зээлийг гүнзгийрүүлнэ.

7. Санхүүгийн зуучлалын зохистой удирдлага, эрсдэлийн хяналтын талаар гарсан шинэлэг ололтыг дэмжин, Банкны тухай хуульд заасан арилжааны банкинд тавих шаардлагад өөрчлөлт оруулна.

8. Хөдөө орон нутагт өрсөлдөөнт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, бичил санхүүгийн үйлчилгээний хүрээг өргөтгөх бодлогын дорвитой арга хэмжээ хэрэгжүүлнэ.

9. Монголбанкунаас арилжааны банкуудын активын чанар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргүүдэд тавих хяналтыг сайжруулж, банкуудын дотоод хяналтын чадвархийг бэхжүүлнэ.

10. Хадгаламж, зээлийн хоршооны санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлж, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авна.

11. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх ажлын хүрээнд банк, санхүү болон хууль хяналтын байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлнэ.

12. Алт, валютын зах зээлийн арилжааны нөөц боломжийг судлан, гадаад зах зээлд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлнэ.

13. Хадгаламжийн давтгалын эрх зүйн орчинг бүрдүүлэх, банкны нягтлан бодох бүртгэлийг олон улсын жишигт нийцүүлэх, мэдээллийн үнэн зөв, нээлттэй байдлыг хангана.

14. Монгол Улсын Их Хурлаас Монголбанкинд тавих хяналтыг тогтмолжуулж, Монголбанкны үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хуралд 2005 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр өргөн мэдүүлэгдсэн санал асуулга явуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын

төслийн хууль санаачлагч өөрчлөгдсөн тул төслийг санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Монгол Улсын 2004 оны улсын төсвийн гүйцэтгэлийг батлах тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын 2004 оны улсын төсвийн гүйцэтгэлийн орлогыг 671.908.307, 4 мянган

төгрөгөөр, зарлагыг 711.245.511,5 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны гишүүдийг томилуулах, дүрмийг батлуулах, Үнэт цаасны хороог зохих журмын дагуу татан буулгах арга хэмжээ авахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Дамиран/-нд даалгасугай.

2. Монголбанк, Үнэт цаасны хороо, Улсын мэргэжлийн хяналтын газрын бүтцэд ажиллаж байгаа банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, даатгал, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий газар, албадыг Санхүүгийн зохицуулах хорооны бүтцэд

шилжүүлэх арга хэмжээг тусгай төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ц.Элбэгдорж/, Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо /Ц.Дамиран/, Монголбанк /О.Чулуунбат/-нд тус тус даалгасугай.

3. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Ц.Элбэгдорж/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 73 дугаар тогтоолын хэвсрэлтээр баталсан "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл"-ийн "Үнэт цаасны хорооны

дарга" гэснийг "Санхүүгийн зохицуулах хорооны дарга" гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2005 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 2/08

Улаанбаатар хот

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим
13.00 цаг

Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, Цэцийн гишүүн П.Очирбат, Л.Рэнчин, Ч.Дашням, Д.Наранчимэг (илтгэгч) нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Хуралдаанд өргөдөл гаргагч Баянгол дүүргийн 16 дугаар хороо, 50 дугаар байрны 19 тоотод оршин суугч, иргэн Д.Янжинхорлоо, Улсын

Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Мөнх-Оргил, Г.Занданшатар нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад зээлдүүлэгч болон Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуульд зэвсээн журмыг зөрчсөн бол зээлдэгч нь шүүхэд гомдол гаргаж болох ба

шүүх уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ”, 27.2-т “Шүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана” гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “...Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна...”, мөн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн “...Монгол улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах...эрхтэй” гэсэн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Өргөдөл гаргагч иргэн Д.Янжинхорлоо өргөдөлдөө: “...2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 заалт нь үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэж буй тул дээрх заалтуудыг хүчингүй болгуулах шаардлага гаргажээ.

Иргэн Д.Янжинхорлоо үндсэн хуулийн цэцэд гаргасан шаардлагынхаа үндэслэлийг дараах байдалаар тайлбарласан байна. Үүнд:

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь банк, банк бус санхүүгийн байгууллагатай зээлийн болон барьцааны гэрээ байгуулсан зээлдэгч зээлийн гэрээний үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан нь үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй” гэсэн заалттай харшилж байгаа юм.

Учир нь Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай

хуулийн 27.2-т зааснаар “шүүх энэ хуулийн 27.1-т зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана” гээд 27.1-т “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад зээлдүүлэгч болон Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол зээлдэгч нь шүүхэд гомдол гаргах болох ба шүүх уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ” гэсэнээр зээлийн барьцаанд тавьсан үл хөдлөх эд хөрөнгийг зээлдүүлэгч шууд өмчлөлд авах үндэслэл болсон гэрээний эрх зүйгээс үүдэлтэй маргааны талаар гомдол гаргах боломжгүй, зөвхөн эрхийн улсын бүртгэлийн алба бүртгэлийг шилжүүлэн хийх үйл ажиллагааны талаар л гомдол гаргах хязгаарлалттай болсон байна.

Гэтэл гэрээний талууд анх гэрээ байгуулахдаа хүсэл зоригоо харилцан зөв ойлголцож, үйлдлийнхээ хууль зүйн үр дагаврыг бүрнээ ухамсарласан эсэх, ийнхүү ухамсарлах эрх зүйн чадамжтай байсан эсэх, гэрээний нэг тал өөрт ашигтай, нөгөө талдаа хэт шударга бус нөхцөл тулган хүлээлгэсэн эсэх, ерөө гэрээний стандарт нөхцөл нь хуульд нийцсэн эсэх, стандарт нөхцөл хүчин төгөлдөр болсон эсэхийг гагцхүү шүүхийн байгууллага хянаж тогтоох эрхтэй. Энэхүү хяналтыг дээрхи шинэ хуулиар хасах нь үндсэн хуульд нийцэхгүй.

Шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй гэсэн зарчмыг ном сурах бичигт томъёолохдоо: “Хүн бүр өөрт нь тулгасан иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, үүргийг нь тодорхойлоход хуулийн дагуу байгуулсан эрх мэдэл бүхий, бусдын нөлөөнд автагдаагүй, гагцхүү хуульд захирагдах шүүхээр хэргээ нээлттэй, шударгаар шийдвэрлүүлэх эрхтэй” гэсэн байдаг.

Банк, банк бус санхүүгийн байгууллагуудын байгуулж буй зээлийн гэрээнүүд гэрээний нэг тал санал болгодог, стандарт нөхцөл агуулдаг. Тэдгээрт зээлийн байгууллагууд өөрсдийн эрх ашгийн үүднээс барьцааны хөрөнгийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах тухай заалт оруулж өгөх нь дамжиггүй. Хууль хэрэгжиж эхэлсэн 2005 оны 9-р сарын 1-нээс эхлэн гэрээг ийнхүү байгуулж эхэлсэн. Гэтэл гэрээнд тавих шүүхийн хяналтыг хассанаар юуны өмнө зээлдэгч иргэдийн эрх ашиг хохироход хүрч байна.

Арилжааны банкууд томоохон хуулийн этгээдүүдтэй хийх хэлцэлд ийм заалт оруулж, улмаар шүүхийн хяналтаас гаргах боломжтой. Учир нь гэрээний талууд аль аль нь зах зээл дээр

мэргэжлийн шинжтэйгээр аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө хуулийн этгээдүүд, бизнесийн үйлдлийнхээ учир холбогдол, эрх зүйн үр дагаврыг сайтар мэдэж байх ёстой гэж тэднээс шаардах бололцоотой, нөгөө талаас мэргэжлийн хуульчдыг ч ажиллуулдаг.

Харин хувиараа эрхлэх гэр бүлийн аж ахуй, тэр тусмаа иргэн хүний хувьд ийнхүү шүүхийн хяналтаас гаргахыг эрх зүйт төрд хүлээн зөвшөөрдөггүй.

Иргэний хууль нь эрх зүйн этгээдүүдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулах гол хууль бөгөөд иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэдэг. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах зарчмын агуулга нь:

1. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид нь эрх, үүргээ хэрэгжүүлэх адил боломжоор хангагдсан байх, өөрөөр хэлбэл, субъект нь хэн байхаас үл шалтгаалан тухайн харилцаанаас бий болох эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Эрх зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага нь адил тэгш байдаг.

2. Харилцаанд оролцогч эрх бүхий этгээдийн шаардах эрх нь үүрэг бүхий этгээдийн үүрэгтэй "эквивалент" шинжтэй, өөрөөр хэлбэл, аль нэг тал нь нөгөөгийнхөө эрх, ашиг сонирхлыг илтэд доройтуулсан, эсхүл нэг тал нь хэт давуу эрхтэй байж болохгүй.

Иргэний хуулийн 2.1-д зааснаар Иргэний хууль тогтоомж нь Монгол Улсын үндсэн хууль, Иргэний хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Иргэний хууль тогтоомжийн системд иргэний эрх зүйн зарим төрлийн харилцааг дагнан зохицуулдаг олон хуулиуд багтдаг. Гэвч Иргэний хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр талуудын тэгш эрхийн үндсэн дээр үүсч, өөрчлөгдөж, дуусгавар болж буй эдийн болон эдийн бус баялагтай холбоотой бүхий л харилцааг зохицуулна. Энэ утгаараа Иргэний хууль нь иргэний эрх зүйн үндсэн эх сурвалж болдог тул тусгай хуулиуд Иргэний хуулийн суурь зарчмыг зөрчөөгүй байх ёстой байдаг.

Иргэний хуулийн 189.4-т Тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил үйлчилгээ, эрхлэх талаар тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд энэхүү үйл ажиллагааныхаа хүрээнд түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй бөгөөд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих буюу гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй гэсэн байдаг. Арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагуудыг санхүү, зээлийн үйлчилгээгээр зах зээлд давамгайлж буй этгээдүүд гэж үзэх бүрэн үндэстэй. Мөн тэдний үйлчилгээг /хүү нь бусад санхүүгийн байгууллагаас арай бага байдаг тул / иргэдийн зүгээс авахаас өөр аргагүй байдаг. Иймд банк, санхүүгийн байгууллагууд иргэдэд тэгш бус нөхцөл тулгахыг ийнхүү тусгай хууль гарган хүлээн зөвшөөрч болохгүй, инөөгийн нөхцөлд шүүхийн журмаар зээлийн барьцааны хөрөнгийг банкууд худалдан борлуулж, учирсан хохирлоо гаргуулж байгаа. Энэ нь тодорхой хугацаа шаарддаг ч шүүх гэрээг бүхэлд нь хянасны эцэст ихэнх тохиолдолд хохирлыг нь гаргуулан шийдвэрлэж байгаа. Энэ тодорхой хугацаанаас болж зээлийн хүү өндөр байгаа, бууруулах боломжгүй байгаа зэрэг нь асуудлын гол шалтгаан бус шалтга юм. Зээлийг угаасаа барьцаа харж олгох ёсгүй, гагцхүү явуулах гэж буй үйл ажиллагааных нь эдийн засгийн ашиг, тооцоо судалгааг харж байж олгох ёстой.

Цаашилбал, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 3.1.1-д зааснаар хэрэглэгч гэж бараа, ажил үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч, үйлчлүүлж байгаа, эсхүл хэрэглэж байгаа хувь хүнийг, худалдагч гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчдэд бараагаа борлуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг хэлнэ. Зээлийн үйлчилгээгээ хэрэглэгчдэд худалдаж буй худалдагч гэж банк, санхүүгийн байгууллагуыг үздэг.

Иймээс гэрээний талууд аль аль нь худалдааны эрх зүйн субъект байх харилцаанд дээрхи хуулийн зохицуулалт байж болох авч, энгийн хэрэглэгч буюу иргэнтэй байгуулсан гэрээний хувьд шүүхээр хамгаалуулах хэрэглэгчийн эрхийг хангаж өгөх ёстой. Шүүхээр хамгаалуулах хэрэглэгчийн эрх гэсэн 8 дугаар зүйлд заахдаа:

Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас хэрэглэгчид учирсан гэм хорыг арилгах,

хохирлыг нөхөн төлөх талаар гаргасан хэрэглэгчийн шаардлагыг үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч биелүүлэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг гэсэн 12 дугаар зүйлийн 12.9-д: Бараа, ажил үйлчилгээг хууран мэхлэх, төөрөгдүүлэх, хүч хэрэглэх замаар худалдах, гүйцэтгэх, хэрэглэгчийн эрх ашгийг хохироосон гэрээ байгуулахыг хориглоно.

Түүнчлэн Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 4.1.1-д бараа бүтээгдэхүүн гэж зах зээлд нийлүүлж байгаа бүх төрлийн эд юмс, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ, шилжүүлж болох эрх зэргийг хэлэх ба 5.1-д: Зах зээлд тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын гуравны нэгээс дээш хувийг дагнан буюу бусад этгээдтэй хамтран хийж байвал давамгайлах байдалтай гэж үзнэ.

Давамгай байдалтай аж ахуйн нэгжид гэрээний зүйлд хамаарахгүй болон гэрээт талд ашиггүй нөхцлийг гэрээнд тусгахыг тулган шаардахыг хориглодог. Хуулийн эдгээр заалт зөрчигдсөн эсэхийг шүүхийн хяналтаар л илрүүлнэ.

Ийнхүү үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн үзэл санаа салбар хуулиудад мөн суусан байтал банк, банк бус санхүүгийн байгууллагаас иргэдтэй байгуулсан гэрээ шүүхийн хяналтаас гадуур үлдэж, банк, банк бус санхүүгийн байгууллагууд давуу эрх эдлэх нь эрх зүйт төрийн үндсэн зарчим болох тэгш байх зарчмыг гажуудуулна.

Өнөөдөр манай иргэдийн дийлэнх нь газар хувьчилж аваагүй байгаа, харин орон сууцны 98 хүртэл хувь нь хувьчлагдсан байгаа билээ. Тиймээс ч зээлийн барьцаанд тавьдаг гол зүйл нь орон сууц бөгөөд амьжиргааны наад захын зайлшгүй эх сурвалж болсон орон байраа барьцаанд тавих гэрээ байгуулсан үйл ажиллагааг шүүх хянахгүй байх нь үндсэн хуульд нийцэх эсэхийг мэргэн оюундаа тунгаан болгооно уу... гэжээ.

Хоёр. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

1. Иргэн Д.Янжинхорлоо үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөлдөө Ипотекний зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль нь Монгол Улсын үндсэн хуулийг зөрчсөн хэмээн үзэж үндэслэлээ тайлбарласан байна.

Тухайлбал, "Гэрээ байгуулсан хүсэл зориг, үйлдлийнхээ үр дагаврыг бүрэн ухамсарласан эсэх, гэрээний стандарт нөхцөл нь хуульд нийцсэн эсэхийг гагцхүү шүүхийн байгууллага хянаж тогтоох эрхтэй. Энэхүү хяналтыг дээрхи шинэ хуулиар хасах нь үндсэн хуульд нийцэхгүй". Түүнчлэн дээрхи хуулийг баталснаас үүдэн энэ төрлийн хэлцэл "шүүхийн хяналтаас гарах боломжтой, ийнхүү шүүхийн хяналтаас гаргахыг эрх зүйт төрд хүлээн зөвшөөрдөггүй" гээд холбогдох хуулийн "заалт зөрчигдсөн эсэхийг шүүхийн хяналтаар л илрүүлнэ" гэжээ.

Өөрөөр хэлбэл, талуудын хооронд маргаан гарсан эсэх, маргагч тал шүүхэд хандсан эсэхээс үл хамааран гэрээний аль нэг тал нь давамгай байдалтайгаар иргэний эрх зүйн харилцаанд оролцож байвал шүүх тухайн хэлцэлтэй холбогдсон асуудлыг заавал хянаж үзэх ёстой, харин Ипотекний зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль нь энэ хяналтыг тавих боломжийг хаасан буюу хязгаарласан гэсэн үндэслэлээр Монгол Улсын үндсэн хуулийг зөрчсөн гэж үзжээ.

Монгол Улсын үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу шүүх нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд "шүүх эрх мэдэлд нэгдүгээрт, эрүү, иргэний төдийгүй, эрх зүйн бусад бүх маргааныг эцэслэн хянан шийдвэрлэх; хоёрдугаарт, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор хөндлөнгийн хяналт тавьж хэрэгжүүлэх" чиг үүрэг хамаардаг.

Харин шүүх гэрээний аль нэг тал нь зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандсанаас бусад тохиолдолд иргэний эрх зүйн харилцаанд хөндлөнгөөс, өөрийн үзэмжээр оролцдог байгууллага биш бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд байгуулсан гэрээ хэлцлийг хуулийн дагуу байгуулсан, эсхүл эрх үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн талаар өөрийн үзэмжээр тухай бүр шалгадаг, хяналын чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага огтхон ч биш юм.

2. Ипотекний зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай" хууль нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр үүсэх бөгөөд гэрээний аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу барьцаанд тавьсан үл хөдлөх хөрөнгийг шүүхийн оролцоогүйгээр худалдан борлуулахтай

холбогдсон асуудлыг зохицуулсан процессийн шинжтэй хууль юм.

Хэрэв талуудын хооронд аливаа хэлбэрээр гэрээ, хэлцэл байгуулаагүй, тухайн гэрээ хэлцлийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй, энэ талаар ямарваа нэгэн нотолгоо, баримт байхгүй бол ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа үүсэхгүй.

Дээр дурдсанчлан ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах харилцаа нь талуудын сайн дурын үндсэн дээр байгуулсан гэрээнд үндэслэн үүсэх бөгөөд энэ харилцаа үүсэхэд төр аливаа хэлбэрээр оролцохгүй.

Өөрөөр хэлбэл, энэ харилцаа нь иргэний эрх зүйн субъектуудын хооронд үүсч буй гэрээний эрх зүйн харилцаа юм.

Харин иргэн Д.Янжинхорлоогийн гаргасан өргөдөлд дурдсанчлан үндсэн хуулиар олгосон хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн эсэх асуудал нь зөвхөн төр, иргэний хооронд үүсдэг онцлог харилцаанд тооцогддог байна.

Энэ талаар Монгол Улсын гавьяат хуульч Б.Чимид "Хүний үндсэн эрх, эрх чөлөөний гол онцлог шинж нь жирийн хүмүүсийн хоорондын харилцаанд биш, төр нийгэмтэй харилцахад буюу нэг талд нь хүн, хүмүүсийн нэгдэл, нөгөө талд нь засаг төр гэгсэн нарийн төвөгтэй харилцаанд хамаарч, илэрч хэрэгждэг, зөрчигддөг" хэмээн бичсэн байна.

Түүнчлэн зээл болон барьцааны гэрээ, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдсон иргэний эрх зүйн харилцааны үед "зээлдэгч" ба "зээлдүүлэгч" хэмээх этгээдүүдийн "субъектив эрх" -ийн асуудал яригдах ба энэ нь үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө буюу "объектив эрх" -ээс тусдаа, өөр ойлголт юм.

Энэ ч уггаараа "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай" хуультай холбогдсон асуудал нь гэрээний эрх зүйн асуудал гэж үзэж байна.

3. үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө нь хүний эдэлж болох зан үйлийн боломж юм. Үүнийг үнэт зүйлсийн дэс дарааллыг тогтоосон каталог гэж үзэх нь ч бий.

Үндсэн хуулийн эрх зүйн онолын үүднээс хүний эрх, эрх чөлөөг 2 үндсэн хэсэгт хамваруулан ойлгож ирсэн. Үүнд:

- төрсөн цагаас нь эхлэн хүн бүрт тэгш хамаарах, хагацаж үл болох эрх буюу жам ёсны эрх /natural right/;

- жам ёсны эрхийг хангах үүднээс үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид хуульчлан бататгасан /төрөөс тогтоосон/ хүний бусад эрх буюу позитив /үүсмэл/ эрх /positive right/.

Жам ёсны эрхийг ямарваа нэгэн хязгааргүйгээр эдэлдэг бол позитив буюу үүсмэл эрхийн хувьд хуулиар тогтоосон зохих хязгаартай байх бөгөөд бусад хүний эдлэх эрх, эрх чөлөөтэй харилцан холбоотой, түүгээр нөхцөлдсөн байдаг. Түүнчлэн хүн позитив эрхээ хэрэгжүүлэхээс тодорхой нөхцөлд өөрийн үзэмжээр татгалааж болдог ба үүнийгээ өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйгээр илэрхийлдэг. Харин ийнхүү татгалзахад нь төрөөс аливаа хэлбэрээр нөлөөлөх ёсгүй байдаг юм байна.

Жишээлбэл, хүн сонгох эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах боломжтой бөгөөд энэ нь сонгуулийн санал хураалтад оролцохгүй байх эс үйлдэхгүйгээр илэрхийлэгдэнэ. Энэ тохиолдолд төр тухайн хүнээс эрхээ хэрэгжүүлэхийг заавал тулгаж, шаардаж болохгүй.

Харин жам ёсны эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах эсэх асуудал нь өнөөг хүртэл маргаантай хэвээр байна (тухайлбал, амьд явах эрхээсээ татгалзах болох эсэх).

Тэгвэл шүүхэд хандах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах нь нэгдүгээрт, шүүхэд гомдол гаргахгүй байх идэвхтэй хэлбэрээр; хоёрдугаарт, гэрээтэй холбогдсон асуудлын хувьд маргааныг шүүхийн бус журмаар /шүүхийн оролцоогүйгээр/, эсхүл үл маргах журмаар шийдвэрлэхээр харилцан тохиролцсон үйлдэл буюу идэвхтэй хэлбэрээр илэрч болно. Үүний нэг жишээ нь арбитраар маргаанаа шийдвэрлүүлэх замаар шүүхэд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах явдал гэж үзэж болно.

Монгол Улсын үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", мөн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "бүх шатны болон дангасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно" гэж тус тус заасан.

Иймээс арбитраар маргааныг хянан шийдвэрлэж байгаа нь Монгол Улсын үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй" байхаар заасныг зөрчсөн гэж үзэх үү гэсэн асуудал үүсэх нь зайлшгүй.

Гэвч арбитр нь талууд хэлэлцэн тохиролцсон тохиолдолд л маргааныг шийдвэрлэдэг бөгөөд энэ талаар "Арбитрын тухай" хуулийн 6.1-д "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2-т заасны дагуу талууд арбитраар шийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон маргаан арбитрын харьяалалд хамаарна" гэж заасан байдаг.

Өөрөөр хэлбэл талууд өөрийн "шүүхэд гомдол гаргах эрх"-ээ тухайн тохиолдолд хэрэгжүүлэхгүй байхаар тохиролцон, маргаанаа арбитраар шийдвэрлүүлэхээр зөвшөөрч, энэ талаараа гэрээ хэлцэлдээ тусгасан тохиолдолд тэдгээрийн маргааныг арбитр шийдвэрлэдэг. Харин нэгэнт арбитраар маргаанаа шийдвэрлүүлсэн тохиолдолд талууд арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй байдаг.

4. "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай" хуулийн 184 дүгээр зүйлд заасны дагуу "талууд гэрээндээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн тохиолдолд" холбогдох журмын дагуу шүүх шийдвэрийг баталгаажуулан шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулдаг.

Энэ нь талууд гэрээгээр харилцан тохиролцсон "шүүхэд гомдол гаргах эрх"-ээ хэрэгжүүлэхээс сайн дурын үндсэн дээр татгалзах боломжийг хуульчилсан заалт юм.

5. Талууд үүргийн гүйцэтгэлийг хангуулахдаа шүүхийн бус журмаар (шүүхийн оролцоогүйгээр) асуудлыг шийдвэрлэхээр анх гэрээ байгуулахдаа зөвшөөрч, харилцан тохиролцсон тохиолдолд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа үүснэ.

Нэгэнт гэрээг талууд сайн дурын үндсэн дээр байгуулсан, ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар (шүүхийн оролцоогүйгээр) худалдан борлуулахыг зөвшөөрч харилцан тохиролцсон бол үг ажиллагааны үед "шүүхэд хандах эрх"-ийг зөрчсөн эсэх асуудал яригдахгүй.

Харин дээр дурдсан нөхцөл нь зөвхөн ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан тодорхой үе шатанд хамаарах тул гэрээний аль нэг тал нь уг ажиллагаа үүсэхээс өмнө шүүхэд аливаа асуудлаар хандах эрхтэй.

Түүнчлэн ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар (шүүхийн оролцоогүйгээр) худалдан борлуулахаар тохиролцсон ч зээлдүүлэгч, эрхийн улсын бүртгэлийн алба ипотекийн зүйлийг шүүхийн

бус журмаар худалдан борлуулах хуульд заасан журмыг зөрчсөн бол зээлдэгч тухайн асуудлаар шүүхэд хандах эрхтэй.

Энэхүү эрх нь "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай" хуулийн 27.1 дэх хэсгээр баталгаажсан болно.

Мөн хуулийн 27.2 дахь хэсгийн заалт нь зөвхөн зээлдэгчид хамаарах тул зээлдэгч эрхийн чадамжгүй байсан, эсхүл хуульд заасан журмын дагуу зохих зөвшөөрөл аваагүй зэрэг үндэслэлээр өөрийн зөрчигдсэн эрх, эрх чөлөөгөө хамгаалуулахаар гуравдагч этгээд шүүхэд хандах эрх нь нээлттэй байна.

6. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль гэрээний талуудад үүргийн гүйцэтгэлийг түргэн шуурхай, зардал багатайгаар худалдан борлуулах сонголт бүхий боломжийг бүрдүүлж байгаа.

Нэгэнт гэрээний талуудад үүргийн гүйцэтгэлийг шүүхийн бус журмаар хангуулах нь ашигтай хэмээн үзэж байхад төрөөс тухайн асуудалд оролцон талуудад ашигтай бус хувилбарыг тулгах нь гэрээний эрх чөлөөнд ноцтойгоор халдаг буй хэрэг юм. Энэ нь гэрээний талуудын эрх ашгийг хөндөөд зогсохгүй, улс орны эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэн, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад хүргэдэг юм байна.

Тухайлбал, Германд үл хөдлөх хөрөнгө, орон сууцтай холбогдсон эрх зүйн зохицуулалт нь нарийн төвөгтэй, төрийн байгууллагаас үл хөдлөх хөрөнгийн зах зээлд нөлөөлөх боломж өндөр байдгаас үүдэн тус улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээл нь амьжиргааны түвшин, хүн амын орлогоор ижил төсөөтэй бусад улстай харьцуулахад харьцангуй доогуур байдаг юм байна.

Гэрээний эрх чөлөө нь эрх зүйн утгаараа талуудад өөрсдөө сайн дураараа, хүсэл зоригоо илэрхийлэн хууль зүйн тодорхой үр дагавар бий болгох эрх чөлөөг олгож, гэрээгээр эдлэх эрх, хүлээх үүргээ иргэний эрх зүйн зохицуулалтын диспозитив аргаар тодорхойлох боломжийг хангахад чиглэсэн байдаг бол эдийн засгийн утгаараа талуудын хооронд баялгыг бүтээхэд чиглэсэн төрөл бүрийн харилцааг чөлөөтэй үүсгэх үндсэн суурь болж өгдөгөөрөө чухал ач холбогдолтой ухагдахуун юм.

Ийм ч учраас эдийн засгийн хөдөлгөгч үндсэн хөдөлгүүр болсон гэрээний эрх чөлөөний зарчмыг тууштай баримтлах нь зөв болов уу ... гэжээ.

Гурав.Өргөдөл гаргагч иргэн Д.Янжинхорлоо 2005 оны 11 дүгээр сарын 15-нд үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэмэлт тайлбартаа:

1. Шүүхийн байгууллагыг өөрийн үзэмжээр иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хоорондын гэрээг хянадаг байгууллага гэж өргөдөлд огт дурдаагүй, ингэх боломжгүй. Гагцхүү иргэний эрх зүйн харилцаанаас эрх нь зөрчигдсөн этгээдийн, эсвэл түүний хууль ёсны төлөөлөгчийн нэхэмжлэл, хүсэлтээр зөрчигдсөн эрхийг сэргээх чиг үүрэгтэй байгууллага гэдгийг хуульч мэргэжил эзэмшсэн хүн бүр мэднэ.

2. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй" гэсэн заалтыг чухамхүү Улсын Их Хурлын баталсан дээрхи хуулийн 27.1, 27.2 дахь хэсгийн заалтаар, тодруулбал "шүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь хуулиараа зөрчиж байгаа юм. Улсын Их Хурал нь эрх мэдэл хуваах онолын дагуу хууль тогтоох засаглалын дээд байгууллага гэдэгтэй эрх биш маргахгүй байх аа.

3. Талууд сайн дурын үндсэн дээр гэрээний харилцаанд ордог нь үнэн. Гэхдээ өнөөдөр Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны 17 банк, түүний дээр олон тооны банк бус санхүүгийн байгууллагууд нь хамтдаа зээлийн үйлчилгээний гуравны нэг буюу түүнээс дээш хувийг үзүүлдэг. Банкны зээлийн хүү хэмгийн бага байдаг зүйл тогтолтой. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн зах зээлд ноёрхох байдал хэмээх 5 дугаар зүйлийн 1-д зааснаар Зах зээлд тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын гуравны нэгээс дээш хувийг дагнан буюу бусад этгээдтэй хамтран хийж байвал давамгайлах байдалтай гэж үзнэ. Энд санхүүгийн байгууллага гэж зээлийн болон даатгалын байгууллага, түүнчлэн үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн зуучлагчийг, бараа бүтээгдэхүүн гэж зах зээлд нийлүүлж байгаа бүх төрлийн эд юмс, төлбөрийн хэргэсэл, үйлчилгээ, шилжүүлж болох эрх зэргийг хэлнэ. Зээлийн үйлчилгээ нь иргэн, хуулийн этгээдүүд хариу төлбөртэйгээр буюу хүү төлж авдаг үйлчилгээ юм. Товчоор банк, банк бус санхүүгийн байгууллагууд нь хамтдаа санхүүгийн зах зээл дээр давамгай байдалтай аж ахуйн нэгжүүд болно.

Иргэний хуулийн 189.4-т зааснаар тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил

үйлчилгээ эрхлэх талаар тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд энэхүү үйл ажиллагааны хүрээнд түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй бөгөөд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих буюу гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй.

4. Арбитр талуудын хэлэлцсэн тохиролцсон тохиолдолд л маргааныг шийдвэрлэдэг нь үнэн. Гэхдээ арбитрын гаргаж буй шийдвэр чанарын хувьд шүүхийнхтэй адил байх ёстой, энэ ч шаардлагад арбитрын байгууллага нийцүүлэн ажилладаг. Гэрээний талууд тэгш эрхтэйгээр гэрээ байгуулах процесст оролцсон, өөрөөр хэлбэл эрхийн хувьд тэгш байдалтай байж чадсан тохиолдолд талууд маргаанаа шүүхээр бус арбитраар шийдүүлэхээр харилцан тохиролцох бүрэн бололцоотой. Талуудын энэ хүсэл зоригийг хүндэтгэх үүднээс шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг билээ. Харин нэг талд нь давамгай байдалтай банк, банк бус санхүүгийн байгууллага, нөгөө талд нь жирийн хэрэглэгч буюу иргэн хүн гэрээ байгуулж буй банкны зээлийн харилцаанд банкны боловсруулсан зээлийн гэрээнд иргэн хүн өөрчлөх бололцоогүйгээр, зөвхөн гарын үсгээ зурах л үлддэг. Энэ гэрээнд банк өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс барьцааны үл хөдлөх хөрөнгийг худалдах шүүхийн бус аргыг сонгох нь дамжиггүй, ингэж ч байгаа. Тэгш байдал хараахан олгогдоогүй талууд гэрээ хийж буй нөхцөлд маргаж буй шинэ хуулийн дагуу зээлдэгч шүүхэд хүртэл хандах эрх нь хаалттай байх нь зүйд нийцэх үү?

5. Гэрээний эрх чөлөөний зарчим нь иргэний эрх зүйн суурь зарчим гэдэгтэй маргахгүй. Гэхдээ энэ зарчимд ч гэсэн хэмжээ хязгаар байдаг. Гэрээний эрх чөлөөний зарчим 3 элементтэй.

1. Гэрээ байгуулах эсэхээ шийдэх эрх чөлөө

2. Гэрээг хэнтэй байгуулахаа харилцан өөрсдөө шийдэх эрх чөлөө

3. Гэрээг агуулын хувьд өөрсдөө чөлөөтэй тодорхойлох эрх чөлөө

Гэрээний эрх чөлөөний зарчмын хэмжээ хязгаар нь хууль, тэр дундаа үндсэн хууль. Тэгш бус байдалтай этгээдүүд гэрээ байгуулчихаад, тухайн гэрээгээр шүүхийн бус аргыг нэг тал нь нөгөөдөө "тулгаж" сонгоод, энэ үйл ажиллагаанд үйлчилдэг хуулиар /Бүр хуулиар шүү/ шүүхэд хандах эрхийг нь хасаж байгаатай хуульч хүний хувьд санал нийлэх үү?

6. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн алба нь Засгийн Газрын нэг л агентлаг болохоос өмчлөх эрхийг зээлийн барьцааны гэрээг үндэслэн дуусгавар болгодог, өмчлөх эрхэд халддаг байгууллага биш. Эндээс барьцааны гэрээг л бүртгэх ёстой. Зөв буруу, эрх нь зөрчигдсөн этгээдийн эрхийг сэргээх үндэслэл, талууд эрх, үүргээ хэрхэн биелүүлсэн, эрх сэргээх арга зэргийг тогтоох эрхийг үндсэн хуулиар гагцхүү шүүхийн байгууллагад олгосон байдаг юм. Иргэн хүний ийнхүү шүүхээр эрхээ сэргээлгэх эрхийг Улсын Их Хурал хууль гаргаж хаах ёсгүй...гээжээ.

Дөрөв. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн төсөлд Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн танхимаас Хууль зүй, Дотоод хэргийн сайдад ирүүлсэн саналд:

1. Монгол Улсын Иргэний хуулийн ипотека буюу үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зохицуулалт нь (танилцуулгад дурьдсанаар) орон сууцны зээлд ямар нэгэн байдлаар садаа болох учиргүй юм.

2. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийг зайлшгүй боловсруулан гаргах ямар шаардлага бий болсон нь ойлгомжгүй байна. Танилцуулгад дурдсанаар хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуулийн ипотекой холбогдсон зүйл заалт өөр хоорондоо зөрчилтэй, зарим асуудал нь тодорхой бус байгаа бол энэхүү хуулийг боловсронгуй болгох асуудал тавигдахаас биш энэ хуулийн үндсэн санаанаас гадуур, өөр үзэл баримтлал бүхий хууль гаргах шаардлагагүй гэж үзэж байна.

Нөгөө талаар Иргэний хуулийн ипотекой холбоотой зүйл заалтууд нь хоорондоо зөрчилтэй байдал шүүхээс уг хуулийг хэрэгжүүлэх явцад ажиглагдаагүй байгаа юм.

Харин ипотекой холбоотой ажиллагаа, тухайлбал, худалдан борлуулах ажиллагаа боловсронгуй биш, хугацаа их шаардагддаг гэх мэт шалтгааныг энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байгууллагын ажлыг сайжруулсанаар арилгаж болох таптай.

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн зорилт нь банк, банк бус санхүүгийн байгууллагаас зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээний үүрэгтэй холбогдуулан ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж

төсөлд заажээ. Гэтэл зээлийн гэрээний харилцааг Иргэний хууль зохицуулдаг ба энэхүү харилцааг өөр ямар ч хууль зохицуулахгүй нь хэнд ч ойлгомжтой зүйл юм.

3. Иргэний эрх зүйн харилцааны үндсэн зарчмуудын нэг нь тухайн харилцааны тэгш эрхийн зарчим байдаг бөгөөд зээлийн гэрээний харилцаанд буюу өмчлөх эрх шилжих гэрээнд ялангуяа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжих тохиолдолд гэрээний аль нэг оролцогчид бусдаас илүү, давуу эрх олгох нь иргэний эрх зүйн дээрх зарчмыг зөрчихөд хүргэнэ.

4. Үүний зэрэгцээ хуулийн өмнө бүгд тэгш эрхтэй байх үндсэн хуулийн зарчим ч ноцтойгоор хөндөгдөж болзошгүй юм. Яг ижил гэрээний харилцаанд оролцож буй өөр өөр этгээдийн эрх, үүрэг өөр өөр байх нь энэ зарчимд нийцэхгүй гэж бид үзэж байна.

Зээлийн гэрээний харилцааг Иргэний хууль зохицуулсаар байхад энэ гэрээний үндсэн шинж буюу гэрээний хугацаа, үүргээ биелүүлээгүйгээс шаардлага тавих эрх зэргийг хуулийн төсөлд (4.1., 5.1.) тусгасан нь ойлгомжгүй байгаагаас гадна хууль тогтоомжийн шатлан захирах ёсыг зөрчиж Иргэний хуульд заагдаагүй зүйл тусгагдсан байна.

5. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зорилтоос үзэхэд улсын бүртгэлийн алба нь өмчлөх эрхийн улсын бүртгэлийг хуульд заасан журмын дагуу хийх эрх бүхий байгууллага байна. Гэтэл Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах тухай хуулийн төсөлд улсын бүртгэгч нь үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх шийдвэр гаргах эрх бүхий этгээд болж хувирч байна.

6. Манай улсад үл хөдлөх эд хөрөнгийн ойлголт жинхэнэ утгаараа дөнгөж бий болж байгаа өнөө үед үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой аливаа харилцааг хөнгөн гоомой, Иргэний хуулийн зохицуулалтаас гадуур, иргэний эрх зүйн харилцааны оролцогч аль нэг субъектын эрх ашгийг илүүд үзэж шийдвэрлэх нь төдийлөн зохимжгүй байгаагаас гадна ер нь хууль тогтоомжийн шатлан захирах ёс, иргэний эрх зүйн шинжлэх ухаанд харш юм.

7. Монгол Улсын иргэний өмчлөх эрхийг хөндөх асуудлыг зөвхөн шүүх шийдвэрлэж байх нь үндсэн хуульд нийцэх тул энэхүү хуулийн төслийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн саналтай ...гээжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад эзэлдүүлэгч болон Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол эзэлдэгч нь шүүхэд гомдол гаргаж болох ба шүүх уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ"; 27.2 дахь хэсэгт "Шүүх 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан байна.

Монгол Улсын үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт: Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй гэж заасан нь иргэдийн хувийн халдашгүй эрхийг шударга шүүхээр хамгаалуулах үндсэн баталгаа юм.

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт "Шүүх 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь Эзэлдэгчийн шүүхэд хандах, шударга шүүхээр шүүлгэх Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хууль гарган шууд хягаарласан гэж үзэх үндэслэлтэй байна.

Харин Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт нь үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад эзэлдүүлэгч болон Эрхийн Улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол эзэлдэгч

нь шүүхэд гомдол гаргаж болох ба шүүх уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ" гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчөөгүй байна.

2. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт "Шүүх 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт "Шүүх 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан Улсын Их Хурлын чуулганаар хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

5. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлэхээр тогтоосугай.

| | |
|--------|--------------|
| ДАРГА | Ж.БЯМБАДОРЖ |
| ГИШҮҮД | П.ОЧИРБАТ |
| | Л.РЭНЧИН |
| | Ч.ДАШНЯМ |
| | Д.НАРАНЧИМЭГ |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 325487
Хэвлэлийн хуудас 4